

# ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ДҮГНЭХ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ХЭРЭГСЛҮҮД

ТОВХИМОЛ

2

ХҮҮХДЭД ХҮНДЭТГЭЛТЭЙ,  
ОРОЛЦООГ ХАНГАСАН ОРЧИН  
БҮРДҮҮЛСНИЙГ ҮНЭЛЖ ХЭМЖИХ  
ТУХАЙ ГАРЫН АВЛАГА



## ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ДҮГНЭХ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ХЭРЭГСЛҮҮД

ТОВХИМОЛ

2

ХҮҮХДЭД ХҮНДЭТГЭЛТЭЙ,  
ОРОЛЦООГ ХАНГАСАН ОРЧИН  
БҮРДҮҮЛСНИЙГ ҮНЭЛЖ ХЭМЖИХ  
ТУХАЙ ГАРЫН АВЛАГА

**Хүүхдийг Ивээх Сан 120 гаруй улсад үйл ажиллагаагаа явуулдаг.  
Бид хүүхдүүдийн амь амьдрал, эрхийнх нь төлөө тэмцдэг.  
Бид хүүхдүүдийг боломж бололцоогоо эдлэхэд нь тусалдаг.**

Энэхүү гарын авлагыг Жерисон Лэнсдаун, Клейр Окейн нар бүтээв.

## Өмнөх үг

Гарын авлагыг бүтээхэд олон хүүхэд, залуус, агентлагууд хувь нэмрээ оруулж ажилласан билээ. Хүн бүрийн нэрийг энд дурдах боломжгүй тул хүлцэл өчөөд, ач тус хүргэсэн явдалд баярлаж талархсанаа илэрхийлье.

Агентлаг хоорондын туршилтын үйл явцыг хоёр жилийн хугацаанд хошуучлан залж ирсэн хорооны дараах нэр бүхий гишүүдэд талархлаа тусгайлан илэрхийлмээр байна: Кавита Ратна (Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судлаач), Алана Капелл (Хүүхдийн хүчирхийллийн эсрэг байнгын төлөөлөгчийн ажлын алба), Билл Бэдхам (“Оролцоо үр дүнгээ өгдөг”), Сара остерланд, Сара Стивенсон, Вера Гам, Элсбет Бо (План Интернешнл), Речэл Тарди Форгакс, Билл Бэл, Ханна Мета (Хүүхдийг Ивээх Сан), Мериам Крамер, Жудит Диерс (НҮБ-ын Хүүхдийн Сан), Филлипа Лей, Пол Стефенсон (Дэлхийн Зөн), Мөн Анна Краули, Жо Федэр, Триша Янг, Клейр Ханбури, Рави Каркара, Аннет Гиертэн, Моника Линдвалл. Туршилтын үйл явц болон Гана дахь олон улсын сургалт семинарт хамтран ажилласан үндэсний мэдээллийн агентлагууд, түүний дотор Нигер дахь “Хөдөлмөр эрхлэгч хүүхэд залуусан Африкийн хөдөлгөөн” байгууллагын Жеймс Боён, Гбедзони Аконасу, Гифт Бралае Эжми, Габриел Семетон Ханж нарт, Энэтхэг дэх “Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн холбоо” ТББ-ын Рошини Нугехали, Анида Сампад нарт, Никарагуагийн ЦЭСЭСМА хөтөлбөрийн Нохеми Торрес, Харри Шиэр нарт болон Малавийн “Хүүхэд бүр” хөтөлбөрийн Люси Моррис, Брюселс Мугого, Энэтхэгийн NCN сэтгүүлийн Эдвин Жон, “Гватемалын төлөвлөгөө” хөтөлбөрийн Жоз Кампан, Хелен

Англи хэлнээс орчуулсан: Н.Гантуяа, Б.Амарсайхан

Орчуулгын редактор: Э.Цолмон

Уг бүтээлийг анх 2014 онд Их Британийн Хүүхдийг Ивээх Сангаас хэвлүүлэв. 2015 онд Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөрөөс Монгол хэлрүү орчуулан Дэлхийн Зөн Монгол ОУБ-тай хамтран хэвлүүлэв.

Энэхүү зургаан бүлэгт ном нь олон улсад зохиогчийн эрхээр хамгаалагдсан болно.

Марализ, “Латин Америкийн төлөвлөгөө” – ний Сантьяго Девила болон Доминикан, Эквадор, Эл Салвадор, Гондурас, Парагвай дахь төлөвлөгөө хөтөлбөрийн ажилтнуудад, Сенегалын олон улсын төлөвлөгөөний Алис Берендс, Тогогийн төлөвлөгөөний Францис Салако, Акакло Дофо Кафуй, Хүүхдийг Ивээх Сангийн Непал дахь салбарын Дев Але, Гурунг Девраж, Хүүхдийг Ивээх Сангийн Клейр Блэк, Ребека Лосон, Зои Девидсон, Гана дахь Дэлхийн Зөн байгууллагын Грегори Дери, Мери Аппая, Фаустина Тиета, Южин Атами, Сесилиа Андерсен, Филип Боаду, Дорис Аджоа Арко Тетте, Мозис Гбекле, Филипа Канза, Замби дахь Дэлхийн Зөн байгууллагын Манянд Чисенга, Лифуна Симуши, Игнатус Муфвидакуле, Дэлхийн Зөн байгууллагын Стелла Нкуруама–Абабио, Жулиан Саймон нарт талархсанаа илэрхийлье. “Царс Сан” (Oak Foundation) –гийн хамт олонд, туршилтын үйл явц болон эдгээр товхимлуудыг бүтээх үйлсэд санхүүгийн туслалцаа үзүүлж, хүүхдийн дуу хоолойг хүргэх мэргэн аргуудыг санаачилж, өөрийн хувь нэмрийг өвөрмөц хэрнээ цаг үеэ олсон байдлаар хүргэж байсанд баярлаад баршгүй юм. “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг зогсоох” хөтөлбөрийн баг хамт олон, ялангуяа Жейн Варбуртон, Фассил Мариам, Анастасия Антопулос нарт талархалаа илэрхийлмээр байна.

Хэвлэлийн ажилд тусалж дэмжсэн Хүүхдийг Ивээх Сангийн Рави Викремасингэ, Сю Макферсон, Барти Мепани нарт баярлалаа.

# ГАРЧИГ

Товхимлыг хэрхэн ашиглах вэ	iv
Танилцуулга	i
1. Хүүхдийн оролцоог хэрхэн хэмжих вэ?	2
2. Шалгуур үзүүлэлтийг ашиглан хүүхдийн оролцооны нөхцөл байдлыг хэрхэн үнэлэх вэ	4
1 Хүүхдийн оролцоог хангасан хууль эрхзүйн орчныг үнэлэх нь	5
2 Хүүхдийн оролцоог таниулахад чиглэгдсэн үйл ажиллагаа, оролцуулах талаар авч байгаа арга хэмжээг үнэлэх нь	8
3 Хүүхдийн оролцоог хангах орчинг ямар түвшинд бүрдүүлснийг үнэлэх нь	11
3. Мэдээлэл цуглуулах	14
Мэдээ цуглуулахын өмнөх бэлтгэл ажил	14
Мэдээ цуглуулахдаа хэнийг хамруулах вэ	15
Олсон мэдээ мэдээллээ бусад эх сурвалжийн мэдээтэй тулгаж үзэх үйл явцад шаардагдах хугацаа	17
Оролцогч талуудаас мэдээ авахдаа ашиглах арга хэрэгслүүд	19
Үзүүлэлт бүрийн эцсийн оноог гаргах нь	25
4. Дүгнэлт	27
Ашигласан эх сурвалжийн жагсаалт	28

# ТОВХИМЛЫГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ

Энэхүү гарын авлага нь таны амьдарч байгаа улс оронд эсвэл нийгэмд хүүхдийн оролцох эрхийг хүндэтгэн дэмжсэн орчинг хэр сайн бүрдүүлсэн болохыг үнэлэхэд тань тус нэмэр болох үзүүлэлтүүд, практик хэрэглэгдэхүүнүүдийг багтаасан. Гуравдугаар хуудсанд, хүүхдийн оролцох эрхийг хамгаалах, оролцох эрхийг сурталчлах ажлыг дэмжих, хүүхдийн оролцооны орон зайг бий болгох зэрэг асуудлыг хөндсөн 25 үзүүлэлт (бүтэц, үйл явц, үр нөлөөг хэмжих)–ийг танилцууллаа.

Тавдугаар хуудаснаас эхлэн дээрх асуудал бүрээр тусгайлан хүснэгт гаргасныг харж болох ба хүснэгтийг ашиглан өөрийн орны нөхцөл байдлыг бүтэц, үйл явцын үзүүлэлтээр үнэлэх (оноо өгөх) боломжтой юм. Хүснэгт ашиглан гаргасан үнэлгээгээ хожим нь суурь мэдээлэл буюу ухуулга сургалтын хэрэглүүр болгох, засгийн газартай хийх хэлэлцээндээ ашиглах юмуу эсвэл оролцооны талаар зөвлөгөө өгөх стратеги боловсруулахдаа хэрэглэгдэхүүн болгон ашиглаж болно.

Хүүхдийн оролцооны үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ (цаашид ХШҮ гэх) хийхийн тулд мэдээ цуглуулахад мэдсэн байвал зохих зүйлсийг гарын авлагын гуравдахь хэсгээс (14–р нүүр) хараарай. Үүнд, мэдээ цуглуулахдаа ямар хүмүүсийг хамруулах, бусад төрлийн мэдээг хаанаас олж авах, мэдээ цуглуулах үйл явц хэр удаан үргэлжлэх зэрэг ойлголт багтана. Судалгаанд хамрагдсан өөр өөр бүлгийн оролцогчдын (хүүхэд, залуус, багш нар, эцэг эхчүүд, төрийн албаны хүмүүс) хүүхдийн оролцоог хүндэтгэсэн орчин бий болсон эсэх талаар ямар бодолтой байдгийг олж мэдэхэд тань тус болохуйц хэрэглэгдэхүүнүүдийг гарын авлагад оруулж өглөө.



**Европын Холбооноос санхүүжүүлж, 400,000 охид хөвгүүдийг хамруулсан хөтөлбөрийн хүрээнд нөхөн үржихүйн хүмүүжил олгох сургалт, хэлэлцүүлгийн бүлэг, клуб, зөвлөгөөнд хамрагдаж буй Этиоп улсын Амхара нутгийн охин**

# ТАНИЛЦУУЛГА

Өнгөрсөн 25 жилийн турш хүүхдийн эрхийг хангах асуудлаар нэлээд ахиц гаргаж чадсан хэдий боловч маш цөөн улс оронд л хүүхэд өөрийнхөө амьдралыг шийдэхэд оролцох боломжоор хангаж чаджээ.

Ерөнхийдөө, нийгэмд хүүхдүүдийг насанд хүрэгчдийн халамж, хамгааллыг хүлээн авагч гэдэг үүднээс харж, 18 нас хүртлээ нийгэмд өрсөлдөх чадваргүй байхаар хуульчилсан байдаг. Хүүхдийн өөрийнх нь мэдлэг, туршлага, сонголтыг үл харгалзан насанд хүрэгчид тэдний өмнөөс шийдвэр гаргадаг. Мэдээж, шүүхийн өмнө хүүхдийн оролцоог хангасан зарим онцгой заалтууд бий л дээ. Тухайлбал, хүүхдийг 16 нас хүрмэгц сонгуульд оролцох эрхтэй болгох, чадвар чадамжийг нь харгалзан үзээд эрүүл мэндийн тусламж авах эсэхээ өөрөө шийдэх, үрчлүүлэх үед сонголтыг өөрөө хийх, шүтэх шашнаа чөлөөтэй сонгох, шүүхийн өмнө гэр бүлийн зарим асуудлаар бие даан мэдүүлэг өгөх гэх мэтчилэн хуулийн тайлбар бүхий заалтууд зарим улсад бий. Гэвч, эрх олгож байгаа үйл ажиллагаа нь тогтворгүй, уялдаа холбоогүй байсаар ирлээ. Хүүхдийн оролцоо гэдэг ойлголтыг зөвхөн Төрийн бус байгууллагуудын хэрэгжүүлдэг хүүхдийн парламент, кампанит ажил, эрхзүйн болон бодлогын асуудлаарх хэлэлцүүлгүүд, бага хуралд хүүхдүүдийг оролцуулах, хүүхдийн клуб байгуулах зэрэг төсөл хөтөлбөрийн хүрээнд л тодорхойлсоор байна. Эдгээр төсөл хөтөлбөр, санаачлагууд нь хүүхдүүд амьдарч буй нийгэмдээ хууль журам, бодлого, үйлчилгээ гээд амьдралд нь хамааралтай өөрчлөлтүүдэд нөлөөлж чаддаг болоход нь туслах нэг гарц болж байгаа нь маргаангүй ч, хүүхдийг өөрийнхөө амьдралын бүхий л үйл явцын идэвхтэй оролцогч болохынх нь хувьд хүлээж авах ойлголтыг томчуудад болоод хүүхдүүдэд бий болгоход төсөл хөтөлбөр дан ганцаараа хүч мөхөсдөнө. Гэр бүл, иргэний болон эрүүгийн шүүх, эрүүл мэндийн байгууллага, сургууль, асрамжийн газар, хүүхдийн хорих гэх мэтчилэн хүүхдийн амьдарч байгаа аливаа газар бүрт хүүхдийн оролцоог дэмжих орчин бүрдүүлэх асуудлыг ярих хэрэгтэй. Хүүхдийн амьдралд шууд нөлөөлөхүйц шийдвэр гаргалтанд төдийгүй явцуу утгаараа, бодлого боловсруулах үйл явц, төрийн үйлчилгээний хүртээмж зэрэг өргөн хүрээний асуудалд ч хүүхдийн оролцоо байх ёстой гэдгийг томчууд сайн ойлгож ухамсарлавал зохино. Хүүхдүүдтэй эсвэл хүүхдийн төлөө ажилладаг багш, эмч, сувилагч, цагдаа, шүүгч, нийгмийн ажилтан, сэтгэлзүйч, асрамж халамжийн газрын ажилтнууд, шашны номлогч гээд бүх хүмүүст, тэдний ажиллаж байгаа салбарын тогтолцоонд нь хүүхдийн оролцоо тухай зөв ойлголт өгөх оролдлогыг байнга хийх хэрэгтэй. Оролцох эрхийг нь хүндэтгэсэн эрхзүйн, бодлогын болоод нийгмийн орчин бүрдсэн байвал түүнийг дэмжих хэрэгтэй. Ийм орчин бүрдүүлэхээс нааш хүүхдийн оролцоо гэдэг нь сайн практик, “халаасны” зорилт хэвээр үлдэх болно. Хэрвээ улс орнуудын засгийн газрууд НҮБ–ын Хүүхдийн Эрхийн Конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх хэрэгтэй юм бол, хийгдэх ёстой өөрчлөлтийн мөн чанар, цар хүрээг тодорхойлж өгөх нь зүйтэй. Гэвч хүүхдийн оролцох эрх (НҮБ–ын Хүүхдийн эрхийн конвенцид тодорхойлсноор)–ийн хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг ямар байгууллагууд хянаж, үнэлэх нь тодорхойгүй байгаа юм. Иймээс засгийн газрууд хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх стратегийн арга хэрэгсэл боловсруулахад, хүүхдийн эрхийн талаар мэргэшсэн зөвлөхүүд ч өөрчлөлт дэвшлийг үнэлэхэд маш хүндрэлтэй байдаг байна. Хүүхдийн оролцох эрхийг хангахын тулд төр засгаас авбал зохих арга хэмжээг Хүүхдийн Эрхийн Комиссоос баталсан 12–р зүйлийн ерөнхий тайлбар дээр маш тодорхой зааж өгсөн байдаг. Энэхүү товхимол нь тус баримт бичигт тулгуурлан, төр засгийн үүргээ ямар түвшинд гүйцэтгэж, ахиц гаргаж байгааг үнэлж хэмжих нарийн тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг багцлан хүргэж байгаа юм.

# I ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ХЭРХЭН ХЭМЖИХ ВЭ?

Дараах 25 шалгуур үзүүлэлтийг бүрэн хэрэгжүүлж чадвал, нийгмийн бүхий л шатанд хүүхдийн тухай ойлголт, байр суурь, тэдний оролцоог дэмжих томоохон өөрчлөлт хийж чадна. Тус шалгуур үзүүлэлтүүдийг бүтцийн, үйл явцын, үр дүнгийн гэж гурав ангилж болно (Диаграм 1). Бидний явуулсан үйл ажиллагааны үр дүнд зөвхөн **бүтцийн** ба **үйл явцын** үзүүлэлтүүдийг гаргаж авсан. Тэдгээр нь хууль журам, тогтолцоо, механизм, төрийн үйлчилгээг авч үзсэний үр дүнд бий болсон үзүүлэлтүүд юм.


**Үр ашгийн** үзүүлэлтүүдийг боловсруулахын тулд хүүхдүүдийн туршлага, үйл ажиллагаанд чанарын шинжилгээ, судалгаа хийх хэрэгтэй болдог. Ингэснээрээ хүүхдийн оролцоо эрхийг хангах чиглэлээр гаргасан хууль тогтоомж, бодлого нь амьдралд хэр үр дүнгээ өгч байгааг мэдэх боломжтой. Энэхүү гарын авлагын гол зорилго нь таны амьдарч буй улсын төр засгийн гаргаж байгаа шийдвэр, явуулж буй үйл ажиллагаа нь хүүхдийн оролцоог хэрхэн хангаж байгааг судлах аргачлалын тухай өгүүлэх тул энд үр дүнгийн үзүүлэлтүүдийг оруулаагүй болно.

Тэдгээр үйл ажиллагаанууд үр дүнгээ хэр өгч байгааг мэдэхийг хүсвэл та дараах чанарын судалгааг хийж болох юм. Тухайлбал, үүнд:

- 1 Хүүхдүүд өөрсдийн эдлэх эрхээ хэр сайн мэддэг тухай
- 2 Орон нутгийнхаа хөгжлийн үйл явцад хэр оролцоотой байдаг талаарх хүүхдүүдийн өөрсдийн санаа бодол
- 3 Гэр бүлийн доторх шийдвэр гаргалтанд өөрсдийнх нь нөлөө хэр байдаг талаарх хүүхдүүдийн санаа бодол

Эдгээр чанарын судалгаа бүрт хамрагдсан хүүхдүүдийг нас, хүйс, газарзүйн байрлал, сургуульд сурдаг эсэх болон бусад хувьсагчаар ангилж авч үзвэл зохино.

**Диаграм 1: Бүтэц, үйл явц, үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд**



1 **Хүүхдийн оролцоо эрхийг хамгаалах нь** (бүтцийн ба үйл явцын үзүүлэлтүүд): Хүүхэд бүрийн дуу хоолойгоо өргөх эрхийг бататгах, түүний стандартыг тогтооход шаардагдах хууль журам, бодлогын багцыг агуулна. Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх, түүнийгээ хүлээн зөвшөөрүүлэх явдал нь зөвхөн тэдний ойр байгаа насанд хүрсэн хүмүүсийн сайхан санаагаар хязгаарлагдахгүйгээр ямар ч улс оронд хуульчлагдсан байх нөхцлийг хангах ач холбогдолтой юм. Эдгээр шалгуур үзүүлэлтүүдээр дамжуулан хүүхдүүдийн санал бодлыг томчууд үнэхээр сонсож, хүлээж авч байгааг илрүүлэх боломжгүй ч оролцоог хангах чухал бүрдэл хэсгүүдийг багтаасан байгаа юм.

- 2 **Оролцооны ач холбогдлыг таниулах ба оролцоо эрмэлзэлтэй болгох** (Үйл явцын үзүүлэлтүүд): Хүүхдүүдэд оролцоо эрхтэй гэдгийг нь ойлгуулах, харин томчуудад хүүхдийн тэр эрхийг хангах талаар хангалттай мэдлэгийг өгөхийн тулд авах арга хэмжээ. Хүүхэд өөртөө ийм эрх байгааг мэддэггүй, ач холбогдлыг нь ойлгоогүй цагт хууль эрхзүйн шинэтгэл хийх, тэдгээр эрхийг хэрэгжүүлэх оролдлогууд бүтэлтэй болохгүй нь мэдээж юм. Үүний нэгэн адил, эцэг эхчүүд энэ эрхийг хүндэтгэж харьцсан цагт л эрхийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх юм.
- 3 **Оролцооны орон зайг бүрдүүлэх** (Үйл явцын үзүүлэлтүүд): Хувь хүн, бүлэг хүмүүс, олон нийт дор бүрнээ хүүхдийн оролцоо эрхийг хангах таатай нөхцөл, тогтолцоог бий болгохын тулд авах арга хэмжээний цогц

Хүүхдийн оролцоо эрхийг хамгаалах	Оролцоо эрхээ мэдэх оролдлого, оролцоо эрмэлзлийг хөхүүлэн дэмжих	Оролцооны орон зай бий болгох
1 Үндэсний хууль тогтоомж болон үндсэн хуулиар оролцоо эрхийг зааж өгсөн байх	11 Боловсрол үнэ төлбөргүй, бас зайлшгүй байх	18 Хууль тогтоох, бодлого үйлчилгээг боловсруулах явцад хүүхдүүдтэй зөвлөлддөг механизмтай байх
2 Энэ асуудлаар хараат бус комиссар эсвэл омбудсманыг томилсон байх	12 Хүүхдүүдийг хараат бус мэдээлэл авах өргөн хэмжээний эх сурвалжуудаар хангах	19 Төрийн бодлого үйлчилгээний чанар, хүртээмжийг хянаж үнэлэх механизмыг хүүхдэд ил болгосон байх
3 Байцаан шийтгэх, шүүх үйл ажиллагааг ойлгоход хялбар, хүүхдэд ээлтэй байж болохоор зохицуулсан байх	13 Төр засгийн мэдээ мэдээллийг хүүхдэд ээлтэй, ойлгомжтой байдлаар хүргэж чаддаг байх	20 Үндэсний болон орон нутгийн засаглалын түвшинд хүүхдүүдийн төлөөллийг заавал байгуулах, түүнээс гадна хүүхдүүд өөрийн байгууллагаараа дамжуулан төлөөлүүлэх боломжтой байх
4 Иргэний болон эрүүгийн хариуцлага тооцох үйл ажиллагаанд хүүхэд үзэл бодлоо илэрхийлэх нөхцлийг бүрдүүлсэн байх	14 Сургалтын хөтөлбөрт хүний эрхийн тухай хичээл багтсан байх	21 Орон нутгийн болон үндэсний хэмжээнд ардчилсан, хүүхдээр удирдуулсан байгууллагууд байгуулагдсан байх
5 Хүүхдийн хөгжиж буй чадамжийг хүндэтгэх явдал нь хуулиар хамгаалагдсан байх	15 Хүүхдүүдтэй ойр ажилладаг мэргэжилтнүүд, бодлого боловсруулагчид хүүхдийн эрхийн тухай сургалтад хамрагдсан байх	22 Хүүхдүүд үзэл бодлоо илэрхийлэхийн тулд хэвлэл мэдээлэлтэй холбоо барих боломжтой байх
6 Төрийн үйлчилгээний өргөдөл гомдлын систем, өргөдөл гомдлыг шийдвэрлэх аргуудыг боловсруулсан байх	16 Эцэг эхчүүдэд боловсрол олгох хөтөлбөр хэрэгждэг байх	23 Сургуулиуд нь хүүхдэд ээлтэй, оролцоог эрхэмлэсэн байх
7 Асран хамгаалал шаардагдсан үед хүүхдүүд амьдралдаа нөлөөлөх шийдвэр гаргалтанд оролцоо эрхтэй байх	17 Хүүхдийн оролцоог хүндэтгэх хандлагын судалгаа хийгдсэн байх	24 Хүүхэд эрүүл мэндийн үйлчилгээнийхээ мэдээллийг хувийн нууцад хамааруулах эрхтэй байх
8 Хүүхдүүд сургуулийнхаа ардчилсан механизмд нэгдэх эрхтэй байх		25 Өөрийн чадавхийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай шийдвэр гаргах эрхтэй байх
9 Хүүхэд өөрийн гэсэн байгууллага байгуулах эрхтэй байх		
10 Эцэг эх, асран хамгаалагчийн үүргийг хуулинд зааж, хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэхийг хуульчилж өгсөн байх		

## 2 ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ АШИГЛАН ХҮҮХДИЙН ОРОЛЦООНЫ НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ХЭРХЭН ҮНЭЛЭХ ВЭ?

Таны үнэлэх асуудал тус бүрээр (**оролцох эрхийг хамгаалах, оролцох эрхээ мэдэх оролдлого, оролцох эрмэлзлийг хөхиүлэн дэмжих, оролцооны орон зай бий болгох**) гурван хүснэгт гаргасан байгаа. Шалгуур үзүүлэлт (эгнээ) тус бүрийг үнэлэх 4 хэмжүүр нэгж (багана) тогтоож өгсөн. Харин хэмжүүр бүр өөрийгөө илэрхийлэх дүрстэй ба тэдгээр нь урвайсан царайнаас инээмсэглэсэн рүү шилжсэн байдалтай байна. Жишээлбэл, эхний хүснэгтэд (хүүхдийн оролцоог хангасан хууль эрхзүйн орчны талаарх хэсэг) урвайсан царай нь хангалтгүй, инээмсэглэсэн царай нь иж бүрэн хангасан, чанартай орчныг илтгэж байна.

Танай орны эрхзүйн нөхцөл байдалд аль багана нь илүү тохирч байгааг тодорхойлох хэрэгтэй (ямар аргаар тодорхойлох тухай 14–19-р талд дэлгэрэнгүй тайлбарласан). Сонгосон баганыхаа нүднүүдийг тодруулах юмуу эсвэл өнгийн харандаагаар будаж, тухайн өгүүлэмжид тохирсон өөрийн орны жишээнүүдийг наадаг цаасан дээр бичиж нааж болно.

Гурвуулаа нийлээд танай оронд хүүхдийн оролцох эрхийг хэр хүндэтгэдэг тухай ойлголтыг үзүүлнэ. Хэрвээ таны тодруулсан нүднүүдийн ихэнх нь зүүн гар талаас эхний хоёр баганад ихэвчлэн харагдаж байвал, таны ажиллаж байгаа улс оронд энэ талаар маш хязгаарлагдмал хүрээнд үйл ажиллагаа явагдсаныг, харин баруун гар талдаа түлхүү байвал хүүхдийн оролцох эрхийг хангах тал дээр нэлээн амжилттай явааг илэрхийлнэ.

Энэхүү хүснэгтээс гарсан дүгнэлт нь төрийн байгууллага, хүүхдийн эрхийн зөвлөхүүд болон хүүхдийн төлөө байгууллагуудад дараах байдлаар ашиглагдаж болно: Үүнд





- Хүүхдийн эрхийг хангах талаар ямар ямар үйл ажиллагаа, нөхцөл бүрдчихээд байгаа болон хууль эрхзүй, бодлого, үйл ажиллагаанд ямар сул тал байгаа талаарх суурь мэдээлэл болгон ашиглах
- Шинэтгэл хийх, зөвлөмж гаргахын тулд өөрчлөлт хийх гол чиглэлүүдийг тодорхойлоход ашиглах
- Тодорхой хугацаанд гарсан ахиц дэвшлийг хэмжихэд ашиглах
- Хүүхдийн Эрхийн Комисст тайлагнах үйл явцад дэмжлэг болох

### 1 ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧНЫГ ҮНЭЛЭХ НЬ

Хууль эрхзүйн орчин	Хангалтгүй	Хязгаарлагдмал	Боломжийн	Иж бүрэн
				
<b>1 Үндэсний хууль тогтоомж, үндсэн хуулиндаа оролцох эрхийн талаар зааж өгсөн эсэх</b>	Хууль эрхзүйн орчинд энэ талаар дурдсан зүйл байхгүй	Эрүүгийн хянан шалгах, шүүх үйл явцын тухай гэх мэт зарим хуульд хүүхэд санал хэлэх эрхийн тухай тодорхой хэмжээнд дурдсан	Хүүхдийн тухай акт, эсвэл түүнтэй дүйцэхүйц хууль журамд хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх, хүүхдийн үзэл бодлыг нухацтай авч үзэх талаар ерөнхийлөн заасан	Улсын үндсэн хуулинд хүүхэд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг баталгаажуулж, боловсрол, эрүүл мэнд, халамжийн зэрэг бусад хууль тогтоомжид ерөнхийлөн заасан
<b>2 Хараат бус комиссар омбудсман томилсон эсэх</b>	Тийм албан тушаал, орон тоо байхгүй	Албан тушаал нь байгаа ч засгийн газраас хараат бус байж чаддаггүй	Хараат бус орон тоо бий ч хүүхдүүдтэй харилцах харилцаа хязгаарлагдмал	Хараат бус комиссарыг зохих хэмжээний төсөвтэйгөөр томилсон ба хүүхдүүдийн дэмжлэгийг хүлээн хүүхдүүдтэй зөвлөлдөх сүлжээ маягаар үйл ажиллагаагаа явуулдаг
<b>3 Шүүхийн шийдвэр гаргах үйл явц нь хүүхдэд ээлтэй, ойлгомжтой байх зохицуулалт хийгдсэн эсэх</b>	Хүүхдэд ээлтэй шүүхийн шийдвэр гаргах үйл явц байхгүй	Хүүхдэд ээлтэй явагдах шүүх хурлын тухай дүрэм журам гарсан боловч практикт хэрэглэгдээгүй	Зарим нэг шүүх ажиллагаанд, ихэвчлэн хот суурин газрын шүүхэд, хүүхдэд ээлтэй зарчмаар ажиллах нь бий	Бүх шүүх ажиллагаанд хүүхдэд ээлтэй үйл явцыг иж бүрэн нэвтрүүлсэн. Хүүхэд бүр эрхийнхээ тухай мэдээллээр бүрэн хангагдсан
<b>4 Иргэний болон эрүүгийн бүх шатны шүүх ажиллагаанд хүүхэд санал бодлоо илэрхийлэх боломжийг бүрдүүлсэн</b>	Иргэний болон эрүүгийн шүүх ажиллагаанд хүүхэд оролцох эрхгүй байдаг бөгөөд хүүхдийн саналыг авахгүйгээр насанд хүрсэн хүмүүс шийдвэр гаргадаг. Хүүхдэд эрхзүйн тусламж өгөх механизм бүрдээгүй.	Хүүхдийн саналыг сонсох, авч үзэх талаар зөвлөдөг мэргэжилтнүүд бий боловч хүүхэд үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй гэж заасан зүйл үгүй. Хүүхэд эрхзүйн тусламж авах механизм боловсруулагдах шатандаа явж байгаа.	Иргэний болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд хүүхдийн оролцоог авч үзнэ гэж хуулинд заасан байдаг ч байнга хэрэгждэггүй. Ихэвчлэн хот суурин газруудад л хүүхэд эрхзүйн тусламж авч чаддаг.	Өөрт хамааралтай, иргэний болон эрүүгийн хэргийн шийдвэрлэх үйл явцад хүүхдийн санал бодлоо илэрхийлэх эрхийг нь хуульчилж өгсөн ба хүүхэд шүүх дээр байр сууриа төлөөлүүлж болно. Эрхзүйн тусламжийн механизм нь улс орны хаана ч хүүхдэд ижил үйлчилж чаддаг.





үргэлжлэл дараагийн нүүрт

**1 ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧНЫГ ҮНЭЛЭХ НЬ** үргэлжлэл





Хууль эрхзүйн орчин	Хангалтгүй	Хязгаарлагдмал	Боломжийн	Иж бүрэн
				
<b>5 Хууль эрхзүйн орчинд хүүхдийн чадамжийг үнэлдэг эсэх</b>	Баривчилгаа, асран хамгаалал, эмчилгээ, шашны гэх мэт асуудлаар хүүхэд байр сууриа илэрхийлэх ямар ч эрхзүйн орчин байхгүй	Хүүхэд 15 нас хүрмэгц үзэл бодлоо илэрхийлэх эрх үүснэ	10 нас хүрмэгцээ үзэл бодлоо илэрхийлэх эрх үүснэ. Харин өөрийнхөө тухай ямар нэгэн шийдвэр гаргах эрх тухайн асуудлаасаа хамааран янз бүрийн насанд үүсэхээр хуулиар тогтоож өгсөн. (жишээлбэл, үрчлүүлэх, эмчилгээ хийлгэх гэх мэт)	Үзэл бодлоо илэрхийлэх чадамж бий болсон цагаас эхлээд энэ эрх нь үүсэхийг хуульчилж өгсөн бөгөөд өөрийгөө төлөөлөн бие даасан шийдвэр гаргах үед заасан насанд хүрээгүй боловч чадамжтай хэмээн тооцогдож байвал шийдвэр гаргаж болно.  Тус хуулийг нийтээр хүлээн зөвшөөрч, дагаж мөрддөг.
<b>6 Төрийн үйлчилгээний өргөдөл гомдол хүлээн авах, шийдвэрлэх арга механизм хөгжсөн эсэх</b>	Өргөдөл гомдол хүлээн авах, шийдвэрлэх механизм бүрдээгүй	Хот суурин газрын зарим хүүхдүүд өргөдөл гомдол гаргаж шийдвэрлүүлэх боломжтой байдаг ч эргэх холбоо султай.	Өргөдөл гомдол хүлээн авах үйл ажиллагаа явагддаг. Тэдгээрийг шийдвэрлэх, хариу өгөх явдал зарим талаар дутагдалтай.	Өргөдөл гомдол гаргах эрх нь хуулиар баталгаажсан ба үйлчилгээний хүртээмж маш сайн. Хариу өгөх, шийдвэрлэх механизм сайн хөгжсөн бөгөөд, идэвхтэй хүртээмжтэй үйл ажиллагаатай.
<b>7 Асран хамгаалал шаардлагатай хүүхдүүд өөрт хамааралтай асуудлыг шийдвэрлэхэд оролцож чаддаг эсэх</b>	Хүүхдээс хамааралгүйгээр томчууд энэ асуудлыг дангаараа шийддэг	Хүүхдийн санал бодлыг авч үзэхийг хуулиндаа заагаагүй	Хүүхэд өөрт хамааралтай асуудлаар шийдвэр гаргахад оролцох ёстойг хуульчилсан ба тэдний санал бодолд зохих ач холбогдол өгдөг. Гэвч хэрэгжилт маш сул.	Хүүхэд хамгаалал, үрчлэлийн бүхий л үе шатанд хүүхдийн санал бодлыг нухацтай авч үзэх ёстойг хуульчилсан. Нийтээр дагаж мөрддөг.

үргэлжлэл дараагийн нүүрт

**2 ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧНЫГ ҮНЭЛЭХ НЬ** үргэлжлэл





Хууль эрхзүйн орчин	Хангалтгүй	Хязгаарлагдмал	Боломжийн	Иж бүрэн
				
<b>8 Сургуулийн орчинд ардчиллын үйл ажиллагаанд хамрагдах эрх</b>	Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх индэр болсон ямар нэг зөвлөл, байгууллага байхгүй	Туршилт маягаар зарим сургуульд сурагчдын зөвлөлийг байгуулсан байдаг ба хамгийн сайн гэсэн сурагчдаа багш нар томилдог. Сурагчид янз бүрийн асуудлын талаар хэлэлцдэг ч шийдвэр гаргахад нөлөө үзүүлдэггүй.	Ихэнх сургууль сурагчдын зөвлөлтэй. Сурагчид зөвлөлийн гишүүдээ өөрсдөө сонгодог. Харин шийдвэр гаргалтанд нөлөөлөх боломжоор хязгаарлагдмал байдаг.	Чухал шийдвэр гаргалтанд хяналт тавих оролцох эрх бүхий сурагчдийн зөвлөл, удирдах хороо сургууль бүрт байдаг ба тус зөвлөл нь сурагчдын ямар ч бүлгийг бүрэн төлөөлдөг.
<b>9 Өөрийн эвлэлдэн нэгдэх байгууллага байгуулах эрх</b>	Хүүхдүүдийг нэгдэл холбоо байгуулахыг нь хуулиар хориглодог. Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүд үйлдвэрчний эвлэлд нэгдэх боломжгүй.	Хүүхдүүд өөрийн удирдлагатай байгууллага байгуулах эрхтэй гэж хуулиндаа заасан боловч төрийн хүнд суртлын тогтолцоо нь албан ёсоор бүртгүүлэхэд их хүндрэл учруулдаг.	Хүүхдүүдээр удирдуудсан байгууллагууд олноор бүртгүүлэх болсон учраас тийм холбоо, байгууллагуудыг байгуулах, бүртгэх үйл явц нь маш хялбар болж ирсэн.	Хүүхэд өөрийн гэсэн байгууллага бий болгох, эвлэлдэн нэгдэх эрх нь хуулиар баталгаажсан. Төрийн байгууллагууд нь хүүхдийн удирдлагатай байгууллагуудыг цаг алдалгүй, ч мэргэжлийн түвшинд хүлээн авах тогтолцоог бий болгосон.
<b>10 Хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэж үзэх зэрэг эцэг эх, асран хамгаалагчийн үүргийг хуулинд тодорхой заасан эсэх</b>	Хүүхдийнхээ үйл ажиллагаанд эцэг эх л шийдвэр гаргах эрхтэй.	Гэр бүлийн доторх шийдвэр гаргалтанд хүүхдийг оролцуулах талаар төр засгаас анхаарал хандуулдаг.	Гэр бүлийн доторх шийдвэр гаргах үйл явцад хүүхдийг хамруулах тухай сургалт сурталчилгааг төр дэмжиж ажилладаг.	Эцэг эхийн үүргийг хуулинд нарийн тодорхой заасан байдаг ба үүнд хүүхдэд нөлөөлөх аливаа шийдвэр гаргахад хүүхдийн санал бодлыг заавал авч үзэхийг тусгасан байна.

**2 ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ТАНИУЛАХАД ЧИГЛЭГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ОРОЛЦУУЛАХ ТАЛААР АВЧ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭГ ҮНЭЛЭХ НЬ**

	Хүүхдийн оролцооны тухай мэдээлэл, ойлголт байхгүй	Хязгаарлагдмал ойлголттой	Ойлголт, мэдээллийн хангамж тодорхой түвшинд байдаг	Ойлголт, баримжаа олгох иж бүрэн хөтөлбөртэй, мэдээллийн хүртээмж сайн.
				
<b>Хүүхдийн мэдлэг ойлголттой болох үйл ажиллагааг дэмжих</b>				
<b>11 Боловсрол үнэ төлбөргүй, заавал эзэмших заалттай</b>	Боловсрол төлбөртэй бөгөөд бага боловсролыг заавал эзэмших ёстой	Бага боловсролыг заавал эзэмших заалттай бөгөөд үнэ төлбөргүй	Бага болон бүрэн дунд боловсрол үнэ төлбөргүй бөгөөд заавал эзэмших заалттай ч сургууль завсардалт их байдаг	Бага болон бүрэн дунд боловсролыг заавал эзэмших бөгөөд үнэ төлбөргүй. Сургуульд бүртгүүлэгч сурагчдын түвшин өндөр хэмжээнд байдаг
<b>12 Хүүхдүүд олон эх сурвалжаас хараат бус мэдээллийг олж авах боломжтой</b>	Хүүхдүүд хараат бус мэдээлэл авах боломжгүй	Хүүхдийн мэдээлэл авах боломж маш хязгаарлагдмал байдаг ба хот суурин газарт харьцангуй дээр	Хүүхдүүд төрөл бүрийн мэдээллийг авах боломжтой боловч нийгмийн ялгаатай бүлгүүдийн хүүхдүүдийн мэдээллийн хүртээмжинд их ялгаа бий	Хүүхдүүд радио, телевиз, номын сан, ном, хэвлэл мэдээлэл, интернет, мэдээллийн лавлахуудаас төрөл бүрийн мэдээллийг авах боломжтой.
<b>13 Төрийн мэдээллийг хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй хэлбэрт оруулан хүргэдэг эсэх</b>	Хүүхдэд ээлтэй хэлбэрт оруулан хүргэдэггүй бөгөөд ялангуяа харааны болон сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд энэ төрлийн мэдээллийг авах бололцоогүй.	Төр засгийн мэдээлэл заримдаа хүүхдэд ээлтэй хэлбэрт хөрвүүлэгдэж гардаг. Гэхдээ бүх хүүхдэд зориулсан нэг төрлийн хэлбэр л байдаг.	Төрийн баримт бичиг, мэдээлэл нь хүүхдэд ээлтэй хэлбэрт хөрвүүлэгдсэн байх нь олонтаа	Мэдээ мэдээлэл нь бүх насны хүүхэд, мөн харааны болон сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдэд тохирсон байдлаар хөрвүүлэгдсэн байдаг. Төрийн байгууллагууд гол баримт бичгүүдээ ийм хэлбэрт хөрвүүлэх үүрэг хүлээдэг.

үргэлжлэл дараагийн нүүрт

**2 ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ТАНИУЛАХАД ЧИГЛЭГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ОРОЛЦУУЛАХ ТАЛААР АВЧ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭГ ҮНЭЛЭХ НЬ** *үргэлжлэл*

	Хүүхдийн оролцооны тухай мэдээлэл, ойлголт байхгүй	Хязгаарлагдмал ойлголттой	Ойлголт, мэдээллийн хангамж тодорхой түвшинд байдаг	Ойлголт, баримжаа олгох иж бүрэн хөтөлбөртэй, мэдээллийн хүртээмж сайн.
				
<b>Хүүхдийн мэдлэг ойлголттой болох үйл ажиллагааг дэмжих үргэлжлэл</b>				
<b>14 Хүний эрхийн тухай мэдлэгийг сургалтын хөтөлбөрт багтаасан эсэх</b>	Сургалтын хөтөлбөрт хүний эрхийн мэдлэг олгох хичээл багтаагүй	Төрөөс сургалтын хөтөлбөрт энэ талаарх мэдлэг олгох сургалтыг оруулах сонирхолтой байгаа. дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй.	Хүний эрхийн тухай мэдлэг олгох хичээлийг хөтөлбөрт багтаасан байдаг ч зарим сургуулиудад л тус сургалт явагддаг.	Хүний эрхийн, тэр дундаа хүүхдийн эрхийн тухай мэдлэг олгох сургалтыг сургуулийн хөтөлбөрт оруулж өгсөн байдаг ба түүнийг заах аргын сургалтад багш нарыг хамруулж, шаардагдах нөхцөл бололцоогоор хангаж өгсөн.
<b>Томчуудын мэдлэг ойлголттой болох үйл ажиллагааг дэмжих</b>				
<b>15 Мэргэжлийн хүмүүс, бодлого боловсруулагчид нь хүүхдийн эрхийн тухай мэдлэг олгох сургалтад хамрагддаг эсэх</b>	Хүүхдийн эрхийн тухай мэдлэг олгох сургалт явуулдаггүй	Зарим нэг мэргэжилтнүүд, бодлого боловсруулагчид ийм төрлийн сургалт семинарт хамрагдсан байдаг.	Хүүхдийн эрхийн талаар мэдлэг олгох сургалтыг мэргэжилтнүүд, бодлого боловсруулагчдын хүрээнд явуулж байгаа	Хүүхдийн төлөө байгууллага болон хүүхэдтэй харьцдаг мэргэжилтнүүдийг бэлтгэх, ажлын байран дээрх сургалтуудад хүүхдийн эрхийн тухай, хүүхдийн чадамжийг хэрхэн үнэлэх тухай сургалтууд багтсан байдаг. Бодлого боловсруулахдаа хүүхдийн оролцоог хангах үүргийн тухай төрөөс бодлого боловсруулагчдад нарийн чиг үүрэг өгдөг

үргэлжлэл дараагийн нүүрт



**2 ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ТАНИУЛАХАД ЧИГЛЭГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ОРОЛЦУУЛАХ ТАЛААР АВЧ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭГ ҮНЭЛЭХ НЬ** *үргэлжлэл*

	Хүүхдийн оролцооны тухай мэдээлэл, ойлголт байхгүй	Хязгаарлагдмал ойлголттой	Ойлголт, мэдээллийн хангамж тодорхой түвшинд байдаг	Ойлголт, баримжаа олгох иж бүрэн хөтөлбөртэй, мэдээллийн хүртээмж сайн.
<b>Томчуудын мэдлэг ойлголттой болох үйл ажиллагааг дэмжих үргэлжлэл</b>				
<b>16 Хүүхдийн эрхийн тухай эцэг эхчүүдэд мэдлэг олгох сургалтын хөтөлбөр</b>	Тийм хөтөлбөр байхгүй	Эцэг эхчүүдэд хүүхдийн эрхийн тухай ойлголт мэдлэг олгох сургалт, сурталчилгааг зарим ТББ, иргэний нийгмийн байгууллагууд зохион байгуулдаг	Төр засгаас хязгаарлагдмал байдлаар иргэний нийгмийн байгууллагуудад тус хөтөлбөрийг боловсруулах нөхцөл бололцоог хангаж өгдөг.	Улс орны өнцөг булан бүрт эцэг эхчүүдэд боловсрол олгох хөтөлбөрийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх боломжтой.
<b>17 Хүүхдийн эрхийг хүндэтгэн үзэх судалгаа хийгдсэн эсэх</b>	Хүүхдийн эрхийг хүндэтгэх байдалд ч, түүний талаарх нийгмийн хандлага, туршлагад хийсэн судалгаа байхгүй	Бие даасан эрдэм шинжилгээний байгууллагууд хүүхдийн оролцооны талаарх хандлага тогтоох судалгаа хийсэн байдаг	Мэргэжлийн хүмүүс сургалтын дараах хүүхдийн эрхийн тухай ойлголт хэрхэн өөрчлөгдсөн талаар судалгаа хийдэг	Хүүхдийн оролцооны тухай ойлголт хандлагын тухай судалгааг бүх мэргэжлийн хүмүүс, бодлого боловсруулагчид, эцэг эхчүүдийн дунд төрөөс судалгаа явуулж, судалгааны үр дүнг бодлого боловсруулахад ашигладаг



ГЭРЭЛ ЗУРАГ: МАЙКЛ ЦЭГЭЕ / ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САН





**Хүйсийн тэгш байдлын талаарх бүлгийн хэлэлцүүлэгт оролцож байгаа Этиоп улсын Амхарагийн охид хөвгүүд**

**3 ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ОРЧИНГ ЯМАР ТҮВШИНД БҮРДҮҮЛСНИЙГ ҮНЭЛЭХ НЬ**

	Оролцох орчин нөхцөл бүрдээгүй	Оролцоо хязгаарлагдмал орчинд хэрэгждэг	Оролцоонд ээлтэй боломжийн орчин бүрдүүлсэн	Оролцох орчин нөхцлөөр иж бүрэн хангасан
<b>Олон нийтийн түвшинд</b>				
<b>18 Хууль боловсруулах, төрийн бодлого гаргах, баялаг үйлчилгээний хуваарилалтыг хийхдээ хүүхдүүдтэй зөвлөлдөх механизм бий болгосон эсэх</b>	Хүүхдүүдтэй хэзээ зөвлөлддөггүй	Зарим бодлогууд дээр зарим хүүхдүүдтэй зөвлөлддөг	Хүүхдэд хамааралтай бодлого бүрийн өөрчлөлт, боловсруулалтын дагуу охид хөвгүүдээс саналын судалгааг системтэйгээр авдаг.	Хүүхдэд хамааралтай, хууль, журам, бодлого боловсруулалтын явцад хүүхдийн санаа бодлыг заавал авч үздэг. Шийдвэр гаргалтанд хүүхдийн байгууллагууд санал бодлоо илэрхийлдэг.
<b>19 Төрийн бодлого үйлчилгээний чанар, хүртээмжийг хянаж үнэлэх механизмыг хүүхдэд ил болгосон эсэх</b>	Төрийн бодлого, үйлчилгээний чанарын талаар санал бодлоо өргөн барих боломжоор хангагдаагүй	Орон нутгийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээ нь өргөдөл гомдлын механизмыг бий болгосон	Төрийн үйлчилгээний байгууллагууд сэтгэл ханамжийн судалгаа, асуумж, өргөдөл гомдол хүлээн авах тогтолцоотой байх үүрэг хүлээдэг.	Төрийн үйлчилгээний байгууллагууд сэтгэл ханамжийн судалгаа, асуумж, өргөдөл хүлээн авах тогтолцоог хэрэгжүүлдэг. Аудитын үйл ажиллагаа нь хүүхдийн оролцоог системтэйгээр хангадаг.
<b>20 Үндэсний болон орон нутгийн засаглалын түвшинд хүүхдүүдийн төлөөллийг байгуулах, түүнээс гадна хүүхдүүд өөрийн байгууллагаараа дамжуулан төлөөлүүлэх боломжтой эсэх</b>	Засаглалын аль ч түвшинд хүүхдийн төлөөлөл байхгүй	Цөөн хэдэн залуусын зөвлөл, хүүхдийн парламент байдаг ч удаан оршин тогтнодоггүй	Хүүхдийг төлөөлөх төрөл бүрийн байгууллагууд орон нутгийн болон үндэсний хэмжээнд байгуулагдаж байгаа	Орон нутгийн болон үндэсний засаг захиргааны нэгжүүд нь хүүхдийн төлөөллийг өөртөө багтаах ёстой хэмээн хуульчилсан байдаг. Шийдвэр гаргах үйл явцад хүүхдээр удирдуулсан байгууллагууд албан ёсоор оролцдог.





*үргэлжлэл дараагийн нүүрт*

### 3 ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ОРЧИНГ ЯМАР ТҮВШИНД БҮРДҮҮЛСНИЙГ ҮНЭЛЭХ НЬ үргэлжлэл

	Оролцох орчин нөхцөл бүрдээгүй	Оролцоо хязгаарлагдмал орчинд хэрэгждэг	Оролцоонд ээлтэй боломжийн орчин бүрдүүлсэн	Оролцох орчин нөхцлөөр иж бүрэн хангасан
				
<b>Олон нийтийн түвшинд үргэлжлэл</b>				
<b>21 Орон нутгийн болон үндэсний хэмжээнд ардчилсан, хүүхдийн удирдлагатай байгууллагууд байгуулагдсан байх</b>	Хүүхдээр удирдуулсан байгууллага гэж байхгүй	Цөөн төрлийн хүүхдийн удирдлагатай холбоод байдаг ба богино хугацаанд үйл ажиллагаа явуулаад татан буугддаг	Хүүхдээр удирдуулсан төрөл бүрийн байгууллагууд улам бүр өсөн нэмэгдэж байна	Үндэстэн, ястан, орон нутгийн хэмжээнд хүүхдийн удирдлагатай төрөл бүрийн байгууллагууд олноор үйл ажиллагаагаа явуулж байна
<b>22 Хүүхдүүд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх боломжтой эсэх</b>	Тийм боломж байхгүй	Залуу сурвалжлагч, нэтрүүлэгч бэлдэх цөөн төслүүд байдаг	Хүүхдүүд хэвлэл мэдээллээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх боломж нэмэгдсээр байгаа бөгөөд энэ нь зарим газар хязгаарлагдмал, харин хот суурин газарт арай бололцоотой байдаг	Хэвлэл мэдээллээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх боломж нь бүх хүүхдийн өмнө нээлттэй, хялбар байдаг. (радио, сонин, интернет, нийгмийн сүлжээ, телевиз гэх мэт)
<b>Өдөр тутамд</b>				
<b>23 Сургуулиуд нь хүүхдэд ээлтэй, оролцоог эрхэмлэсэн эсэх</b>	Хүүхэд төвтэй заах аргачлал хөгжөөгүй	Цөөн хэдэн сургуульд энэ төрлийн заах аргазүйг туршиж байгаа	Энэ төрлийн заах аргазүй нь улс орон даяар дэмжлэг хүлээсэн	Сургуулиуд хүүхэд төвтэй заах аргазүйг заавал хэрэгжүүлэх үүрэгтэй
<b>24 Хүүхэд эрүүл мэндийн үйлчилгээнийхээ мэдээллийг хувийн нууцад хамааруулах эрхтэй эсэх</b>	Эрүүл мэндийн үйлчилгээ авахын тулд хүүхдэд заавал эцэг эхийн зөвшөөрөл хэрэгтэй	Бие даасан эрүүл мэндийн төвүүд өсвөр насныханд зориулсан клиник ажиллуулдаг. Гэхдээ нууцлалын талаар тодорхой бодлогын баримт бичиг байхгүй	Эмнэлгийн зарим үйлчилгээ үнэ төлбөргүй ба бага болон өсвөр насныханд ээлтэй байдлаар хүрдэг. Нууцлалын бодлого нь зөвхөн хот суурин газарт л хэрэгждэг	Хүүхэд, өсвөр насныханд ээлтэй, үнэ төлбөргүй, нууцлал бүхий эрүүл мэндийн үйлчилгээг улс орон даяар үзүүлдэг ба нийтийн ойлголт маш сайн

үргэлжлэл дараагийн нүүрт

### 3 ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ОРЧИНГ ЯМАР ТҮВШИНД БҮРДҮҮЛСНИЙГ ҮНЭЛЭХ НЬ үргэлжлэл

	Оролцох орчин нөхцөл бүрдээгүй	Оролцоо хязгаарлагдмал орчинд хэрэгждэг	Оролцоонд ээлтэй боломжийн орчин бүрдүүлсэн	Оролцох орчин нөхцлөөр иж бүрэн хангасан
				
<b>Өдөр тутамд үргэлжлэл</b>				
<b>25 Авах эрүүл мэндийн тусламж үйлчилгээнийхээ талаарх шийдвэрийг оорийн чадамжийн хэмжээнд гаргах эрхтэй эсэх</b>	Эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээ авах шийдвэрт 18 хүрээгүй хүүхэд оролцохгүй	Анагаах ухааны зарим ажилтнууд том хүүхдүүдтэй энэ талаар зөвлөлдөх нь бий. Гэвч үүнийг зохицуулсан бодлого байхгүй	Авах эмчилгээнийх нь тухайд хүүхдийг оролцуулж шийдвэр гаргах нь зөв гэдгийг эмч нар ухамсарладаг ба/эсвэл үүнийг зохицуулсан бодлоготой боловч энэ асуудлаар сургалт сурталчилгаа хийгддэггүй, хэрэгжилт хангалтгүй	Аль болох хүүхдийн өөрийнх шийдвэрийг харгалзан үзэхийг эмнэлгийн ажилтнуудад үүрэг болгосон бодлогын баримт бичиг байдаг. Насанд нь тохирсон мэдээллийг хүүхдэд өгдөг ба эрүүл мэндийн мэргэжилтнүүд бодлогын хэрэгжилтийг хангах талаарх сургалтад хамрагдсан байдаг



ГЭРЭЛ ЭВАГ: РЕЙЧЛ ПАРМЕР/ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САН

### 3 МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ

#### МЭДЭЭ ЦУГЛУУЛАХЫН ӨМНӨХ БЭЛТГЭЛ АЖИЛ


Шалгуур үзүүлэлт, үнэлгээнүүдээ гаргаж чадсан бол одоо судалгаанд ашиглах мэдээ цуглуулах хэрэгтэй. Мэдээ цуглуулж эхлэхийн өмнө дараах зүйлсийг сайтар тунгааж үзэх нь зүйтэй. Үүнд:

- Хүснэгтэд байгаа бүх шалгуур үзүүлэлтүүдэд (хэвтээ) ямар нөхцөл байдлыг хангалттай, хязгаарлагдмал, боломжийн, эсвэл иж бүрэн орчин нөхцөл бүрдүүлж чадсан гэж үзэж болох талаар өгүүлэмжүүдийг өгсөн байна. Эдгээр нь зүгээр л танд чиглэл өгч байгаа юм. Танай нийгмийн нөхцөл байдалд тэдгээр шалгуур үзүүлэлтүүдийг хэрэглэхэд тохиромжгүй бөгөөд өөр бусад аргачлалууд шаардлагатай болж мэдэх юм. Өөрийн гэсэн өгүүлэмжүүдийг зохиож тухайн хүснэгтийн нүднүүдэд байрлуулж ч болно. Эмзэг бүлгийн болон балчир насны хүүхдүүд, охидууд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд гэх мэт бусад бүлгүүдийг харгалзан үзсэн шалгуур үзүүлэлтүүдийг өөрөө зохиож болно.
- Ажиллаж байгаа орныхоо нөхцөл байдалд тохируулан “Үр дүнгийн үзүүлэлтүүд”-ийг зохиож болно. Жишээлбэл, хүүхдийн удирдлагатай байгууллагууд олон байгаа тохиолдолд сүүлийн таван жилд тухайн байгууллагуудад хамрагдсан хүүхдүүдийн тоог авах зэргээр судалгаа хийх боломжтой. Эсвэл сурагчдын өөрөө удирдах байгууллагатай сургуулиудын эзлэх хувийг тогтоож, тус сургуулийн сурагчид шийдвэр гаргалтанд оролцох оролцооныхоо талаар сэтгэл ханамж нь хэр байгааг судалж болно.

Иж бүрэн төсөөлөл гаргахын тулд хүүхдүүдийг нас, хүйс, хөгжлийн байдал, нийгмийн гарал, үндэс угсаа, хот хөдөөгийн ялгаа болон бусад хүчин зүйлээр нь ангилан авсан мэдээгээ тус тусад нь үнэлэх боломжтой. Тухайлбал, хүүхдийн сайн дурын клубуудын талаар судлах бол тийм клубууд улсын аль хэсгүүдэд түлхүү төвлөрч, ямар хүүхдүүд түүнд хамрагдаж байгааг мэдэх хэрэгтэй болно. Ингэхийн тулд тийм клубуудтэй холбогдож, хэр олон хүүхэд хамрагддаг, түүний дотор хэдэн эрэгтэй, хэдэн эмэгтэй хүүхэд байгаа, 12-оос доош насны хэд, 12-оос дээш насны хэдэн хүүхэд байгааг асууж болно. Авсан мэдээгээ бүлгээр ангилснаар, нийгмийн ялгаатай бүлгүүдийн (ялгаварлан гадуурхагддаг болон хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт) хүүхдүүд оролцох эрхээ хэрхэн ялгаатай эдэлж байгааг мэдэх боломжтой. Өргөдөл гомдлын тогтолцоог авч үзээд, ямар бүлгийн хүүхдүүд энэ тогтолцооны ашиг тусыг хүртэж байна вэ, бас яагаад ийм байдал үүсэв гэдгийг мэдэх нь чухал. Тухайн тогтолцоог охид, хөвгүүд, аль ч насны хүүхдүүд ижил түвшинд ашиглаж чадаж байна уу үгүй юу? Хэрэв тийм биш бол шалтгаан нь юунд байна, яаж сайжруулж болох вэ?

Тухайн мэдээллийг та янз бүрийн байдлаар харуулж болно. Дараагийн нүүрт байгаа Зураг 2 нь охид хөвгүүдийн оролцох эрхээ хэрхэн ялгаатай эдэлж байгааг харуулах нэг жишээ юм. Хүүхдийн удирдлагатай байгууллагын үйл ажиллагаанд долоо хоногийн гурван цагийг зарцуулдаг охид хөвгүүдийн хувийг насны бүлгүүдээр ангилан харуулав.

**Зураг 2: Хөтөлбөрт хамрагдсан охид хөвгүүдийн оролцоог харуулсан жишиг график**



#### МЭДЭЭ ЦУГЛУУЛАХДАА ХЭНИЙГ ХАМРУУЛАХ ВЭ

Хэр их мэдээ цуглуулах шаардлагатайг албан байгууллага өөрөө тодорхойлно. Хамгийн сонгодог шийдэл бол судалгааг санаачлах, үгүй бол, гол хамтрагчаар оролцох явдал юм. Хамрагдах хүмүүсийн тоо хэдий олон байх тусмаа судалгааны үр дүн төдий чинээ бодитой гарах нь ойлгомжтой. Улс орны өөр өөр бүсээс ирсэн хүмүүсийг оролцуулвал илүү үр дүнтэй. Жишээлбэл, хот суурин газрын хүүхдүүд хөдөөгийн алслагдмал газар амьдардаг хүүхдүүдээс сургуульд хамрагдалт, эрүүл мэндийн үзлэгт орох, орон нутгийн төлөөллийн байгууллагад хамрагдах боломжоор ялгаатай байж таарна. Үүний нэгэн адил, эцэг эх нь хүүхдийнхээ эрүүл мэндэд мөнгө зарцуулж чаддаг байвал тухайн айлын хүүхдүүд ядуу айлын хүүхдүүдийг бодвол илүү их эрүүл мэндийн үйлчилгээ авч, эмч нарын хандах хандлага түүнийгээ дагаад илүү сайн байдаг байж болно. Тусгай сургуульд сурдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд сурагчдын зөвлөл байгуулах нь хүндрэлтэй асуудал байдаг байж болно.

Хүүхдийн оролцох эрхийн талаарх төсөөллийг бүрэн гаргаж ирэхийн тулд дээрх бүх зүйлийг тооцох хэрэгтэй. Оролцох эрхийн тухай «практик» ойлголтыг авахын тулд хүүхдүүдийг өөрсдийг нь болон, бусад оролцогч талуудыг хамруулсан мэдээг цуглуулах хэрэгтэй. Хүүхдүүд өөрсдөө сурагчдын өөрөө удирдах байгууллага байгуулах эрхийг нь авч үзье. Энэ асуудлаарх төрийн байгууллага, орон нутгийн удирдлага, багш, хүүхдүүдийн үзэл бодлыг авч үзэх нь чухал. Хүүхдийн оролцох эрхийн талаар гаргасан бодлогын баримт бичиг байгаа гэж төрийн албан хаагчид хэлж байгаа боловч бодит байдал дээр сурагчдын өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа хүүхдэд хүртээлгүй, ихэвчлэн багш нарын удирдлага дор байдаг учраас сурагчдын үзэл бодол нэг их нөлөө үзүүлдэггүй гэж хүүхдүүд хэлж магадгүй. Энэ бүх хүчин зүйлийг тооцож үзсэний үндсэн дээр баганан дахь шалгуур үзүүлэлтүүдээс алийг нь сонгохоо шийдэх хэрэгтэй. Таны цуглуулж байгаа мэдээ бол анхан шатны мэдээ юм.

Бүх төрлийн оролцогчдын төлөөллийг оролцуулан хүснэгтэд байгаа өгүүлэмжүүд дээр санал бодлыг нь авч болно. Хүүхэд, залуус, төрийн албан хаагчид, мэргэжилтнүүд (боловсрол, эрүүл мэнд, эрхзүй гэх мэт бүх салбарт ажилладаг), эцэг эхчүүд, ТББ-ын төлөөлөл гээд бүх оролцогч талуудыг нэг дор цуглуулж уулзах аргыг ашиглах боломжтой. Эсвэл бүлэг бүрээр ангилж, тус тусад нь уулзалт зохион байгуулж болно. Аль аль арга нь сул ба давуу талуудтай:

- **Оролцогч талуудын холимог уулзалт:** өөр үзэл бодолтой хүмүүсийг нэг дор цуглуулснаар, тэдэнд бие биенийхээ үзэл бодол, амьдрал дээрх туршлагыг сонсож, мэтгэлцэх, ингэснээрээ нэгнээ илүү ойлгож үзэл бодлоо өөрчлөхөд нь тус болох болно. Гэвч бүлэг хоорондын ялгаатай үзэл бодол сайн илэрч гарахгүй байх талтай.
- **Тусгай уулзалт:** нийтлэг нөхцөл байдалд байдаг учраас оролцох эрхээ хэрхэн эдэлж байгаа талаараа нарийн хэлэлцэхэд илүү их цаг, орон зай бий болгодог. Хэдий тийм боловч бүлгүүдийн уулзалт нь ямар өөрчлөлт хийх талаар янз бүрийн сонирхолтой санаа дэвшүүлдэг юм. Мэдээж, хамруулах хүмүүсийн тоо хэмжээ нь таны ажиллаж байгаа улс орны байдал, өөрт байгаа нөөц бололцоо зэргээс хамаарна. Улс орны өөр өөр хэсгүүдээс мэдээ цуглуулах боломж байхгүй бол харьяалал өөртэй томчууд, хүүхдүүдийг цуглуулж, нутаг орныхоо хүмүүсээс мэдээ авах ажлыг зохион байгуулж болно.



Сургуульд хүүхэд эрхээ эдлэх талаарх хүүхдийн удирдлагатай судалгаанд хамрагдагч судлаач-хүүхэд «хүүхдийн эрхийг хүндэтгэсэн» орчинтой төгс сургуулийг зурсан зургаа үзүүлж байна. Ла Далиа, Никарагуа

## ОЛСОН МЭДЭЭ МЭДЭЭЛЛЭЭ БУСАД ЭХ СУРВАЛЖИЙН МЭДЭЭТЭЙ ТУЛГАЖ ҮЗЭХ

Бүлэг хоорондын холимог уулзалтуудаас олж авсан мэдээгээ бусад олон төрлийн эх сурвалжийн мэдээтэй харьцуулан тулгаж үзэх хэрэгтэй. Ингээд **хоёрдогч мэдээг гаргаж ирэх юм. Мэдээллийн олон эх сурвалжуудтай байвал хүүхдийн оролцооны талаар илүү үнэн бодит төсөөлөлтэй болж чадна. Хоёрдогч мэдээллийг дараах эх сурвалжуудаас авч болно.** Үүнд:

- эрдэм шинжилгээний байгууллага, үндэсний болон олон улсын ТББ, НҮБ-ын Хүүхдийн төлөө байгууллагаас хүүхдүүдийн дунд хийсэн болон хүүхдээр гүйцэтгүүлсэн судалгааны ажлын баримтууд
- хэвлэлийн мэдээ, тайлан, сонингийн хайчилбар
- төрийн бодлого, хууль тогтоомж
- үндэсний болоод орон нутгийн хэмжээнд төсвийн хуваарилалт ба зарцуулалт
- холбогдох асуудлаарх төрийн стратегийн баримт бичгүүд, төлөвлөлт (жишээ нь, боловсрол, эрүүл мэнд, хүүхдийн гэрлэлт, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, ХДХВ гэх мэт)
- холбогдох яам, албан байгууллагуудаас авсан мэдээ (жишээ нь, шүүхийн шийдвэр гаргах үйл явцад өөрийгөө төлөөлүүлсэн хүүхдийн тоо, ардчилсан хэв маягтай сурагчдын зөвлөл бүхий сургуулийн улсын хэмжээнд эзлэх хувь)
- НҮБ-ын Хүний Эрхийн Комисс-т илгээдэг засгийн газрын хугацаат болон, ээлжит бус тайлангууд, Universal Periodic Reviews; болон бусад хүний эрхийн тайлангууд
- Хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтийн ажиглалт, Хүний эрхийн зөвлөл гэх мэт гэрээний байгууллагуудын хэрэгжилтийн тайлан зэрэг багтана.

Зарим эх сурвалжаас мэдээ авахад амархан, заримаас нь авахад хэцүү байдаг. Жишээлбэл, хүүхдийн оролцох эрхийг баталгаажуулсан хууль журам байгаа эсэх, сургуулиудад сурагчид өөрөө удирдах байгууллага байгуулах эрхтэй байдаг эсэхийг олж мэдэхэд их амархан. Харин эрүүл мэндийн үйлчилгээ хүүхэд болон өсвөр насныханд ээлтэй байдлаар явагддаг эсэх, хяналт шалгалтанд хүүхдүүд оролцдог эсэх, хүүхдийн эрхийн талаарх сургалт сурталчилгаанд хамрагддаг эсэх талаарх мэдээг авахад зоримог, шаргуу судалгаа хийх шаардлагатай. Мөн ялгаатай эх сурвалжаас авсан мэдээллүүд чанарын хувьд бас өөр хоорондоо маш их ялгаатай байдаг. Тухайлбал, нэр хүндтэй их сургуулиас авсан мэргэжлийн түвшний судалгаагаар олсон мэдээ чанар сайтай байх нь дамжиггүй. Гэтэл хэвлэлийн мэдээ, сонинны хайчилбар нь аль нэг талыг хэт баримталсан юмуу, ямар эх сурвалжаас авсан мэдээлэл болох нь мэдэгдэхгүй байх талтай.



Колумб улсын Меделлин хот буюу тус улсын хамгийн ядуу, гэмт хэргийн гаралт өндөртэй бүс нутаг дахь семинар – ардчилал, хүний эрх, энх тайвнаар зэрэгцэн орших сэдвээр явагдаж байна

### ҮЙЛ ЯВЦАД ШААРДАГДАХ ХУГАЦАА

Мэдээ цуглуулахад зарцуулах цаг хугацааны талаар нарийн тодорхой зөвлөмж өгөхөд төвөгтэй. Улс орны хөгжлийн түвшин, хүн амын тоо, нөөц бололцоо, мэдээ цуглуулахад туслах хүмүүсийн тоо хэмжээнээс хамааран хэлбэлзэх нь тодорхой. Судалгааны зорилго юунд чиглэж байгаагаас хамаарч мэдээ цуглуулах хугацаа нь өөр өөр байна. Жишээлбэл, шалгуур үзүүлэлтүүд хэр сайн хангагдсан тухай “хар зураг” гаргахын тулд төрөл бүрийн оролцогч талуудыг хамарсан нэг удаагийн уулзалт зохион байгуулсан байж болно. Оролцогч талуудыг хүүхдийн оролцоог хангах (НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн 12 дугаар бүлэгт зааснаар) тал дээр маш их өөрчлөлт хийх шаардлагатай байгааг ойлгоход нь тус болох сайн арга болно. Ийм холимог уулзалтуудаар хүүхдүүд, төрийн байгууллагын удирдлагуудыг уулзуулж, хэлэлцээрийн ширээний ард суулгах нөхцөл бололцоог ч бүрдүүлж байгаа юм. Тус уулзалт нь мэдрэмжийн судалгаа хийх нөхцөл болж ч болох бөгөөд оролцооны талаар зөвлөмж боловсруулахад хэрэг болно. Нөгөөтэйгүүр, суурь шинжилгээг хийхэд тус уулзалтын үр дүнг ашиглах боломжтой. Суурь шинжилгээ гэдэг нь аливаа төсөл хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнөх үеийн хүүхдийн оролцооны байдлын илтгэлцүүр юм. Хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтийг хянах хороонд хүргүүлэх тайланг бэлдэх суурь мэдээллүүдийг боловсруулах нь үүнээс эхэлнэ. Тухайн тайлан буюу нарийвчилсан судалгааны материал боловсруулах, үзэл бодлын ялгаатай байдлыг илрүүлэхийн тулд оролцогч бүлэг бүрийн төлөөллийг хуралдуулж шалгуур үзүүлэлт бүр дээр үнэлгээ өгүүлэх хэрэгтэй. Энэ үйл явц хэдэн сарын хугацаа шаардаж магадгүй юм. Хүүхэд залуустай цаг гарган хуралдаж, ямар арга хэмжээ явуулбал зохих талаар ярилцаж болно. Дараа нь судалгааны зорилтот үр дүнд хүрэхийн тулд хэрэглэх аргачлалаа боловсруулна. Иж бүрэн, нарийвчилсан дүн шинжилгээ, тайлан гаргах зорилгоор тодорхой санхүүжилт хайх боломжтой.

### ОРОЛЦОГЧ ТАЛУУДААС МЭДЭЭ АВАХДАА АШИГЛАХ АРГА ХЭРЭГСЛҮҮД

Давын өмнө, бүх оролцогч талуудын төлөөллийг цуглуулан шалгуур үзүүлэлтүүдийг танилцуулах ба үзүүлэлт тус бүр дээр гаргах саналыг нь сонсоно. Ийм арга хэмжээг ямар шалтгаанаар явуулж байгаа, ямар үр дүнд хүрэх зорилготой, мэдээ цуглуулахдаа ямар аргачлал хэрэглэх талаараа бүх хүнд тайлбарлаж өгөх хэрэгтэй. Бүлгийн хэлэлцүүлэг, ярилцлага, асуумж зэрэг янз бүрийн аргачлалуудаас сонгоорой. Товхимол 5 –аас бэлэн аргачлалуудыг хэрхэн ашиглах тухай зөвлөмжийг үзээрэй. Харин энэ хэсэгт, оролцогч талууд, хүүхдүүдээс хэрэгтэй мэдээг цуглуулахад ашиглаж болохуйц оролцоонд суурилсан арга хэрэгслүүдийг оруулав. Бүлгийн уулзалт, ярилцлага, асуулга судалгаатай хамт болон орлох маягаар хэрэглэж болох дарах аргууд нь илүү харилцаанд суурилсан, хүүхдэд ээлтэй аргууд юм.

#### “1 SPACEOGRAM” ДҮРЭМ – БИ ХЭР ОРОЛЦДОГ ВЭ?

“Оролцоо” хэмээх ойлголтыг бүлгээр анхлан хэлэлцэж эхлэх үед ихэвчлэн энэ аргыг хэрэглэдэг. Тус арга хэрэгсэл нь:

- амьдралын өөр өөр орчин нөхцөлтэй судалгаанд хамрагдагсад оролцооныхоо түвшинг таньж ойлгох, хэлэлцэх боломж олгодог.
- хүүхдийн оролцоо бага юмуу их байгаа нөхцөл байдал, газар орныг тодорхойлдог (гэр бүл, сургууль, орон нутаг, тосгон, байгууллагууд, нийслэлийн засаг захиргаа гэх мэт), ингэснээрээ «оролцоо» гэдэг ойлголтын тухай бидэнд гүн гүнзгий мэдлэг өгдөг
- хүүхдүүд ямар шалтгааны улмаас оролцохгүй байгаа тодорхойлдог.
- төсөл хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнөх үед хүүхдүүдийн оролцоо ямар байгаа, хүүхдүүд ямар үйл ажиллагаанд түлхүү оролцож байгаа талаар түргэвчилсэн ойлголт өгнө. Бодлогын баримт бичгүүд нь бодит байдал дээр хүүхдийн оролцоог хэрхэн сайжруулж байгааг тодорхойлоход тус болдог. Жишээ нь, хуулинд зааснаар хүүхэд өөрийн гэсэн нэгдэл холбоог байгуулж болох боловч тэр үйл ажиллагааг нь дэмжих хүчин зүйлс байхгүй байж болох юм. Залуус, өсвөр насныхан, томчуудад энэ арга яг адил хэмжээнд үйлчилдэгт гол онцлог нь оршино. Тараах картууд дээрх өгүүлбэрүүдийг хүүхдийн насны бүлэгт тохируулан өөрчлөхөд л хангалттай. Түүнчлэн тавих асуултуудаа ч ярилцаж байгаа сэдвийнхээ дагуу өөрчлөх боломжтой.

#### Шаардагдах хугацаа

40–60 минут (хэлэлцүүлгийг хэр удаан хийхээс хамааран өөрчлөгдөнө).

#### Шаардлагатай хэрэгслүүд

Нэг нь “Би оролцдоггүй”, нөгөө нь “Би бүрэн оролцдог” гэсэн хоёр том тэмдэг; өгүүлбэртэй картууд (доор үзүүлсэн); лекцийн тэмдэглэл, фломастерууд, дараагийн хэлэлцүүлэг хэрэгтэй гэж үзвэл скоч хэрэг болно

**Явц**

- Хоёр тэмдгээ өрөөний хоёр талд байрлуулж, хүмүүсээ өрөөний дунд зогсооно.
- Spaseogram –ын дүрмийг танилцуулна. хоосон зай ба диаграмын холимог юм. Картан дээрх өгүүлбэрүүд бүр дээр тус өгүүлэмжийн хүрээнд ямархуу оролцоотой байж чаддагаа бодох ёстой. хэрвээ огт оролцож чаддаггүй бол “би оролцдоггүй” гэсэн тэмдгийн ойр очиж зогсоно. харин байнга оролцож чаддаг бол “би бүрэн оролцдог” гэсэн тэмдгийн хажууд зогсоно. Энэ хоёр тэмдгийн хоорондох зай бол харьцангуй оролцооны хэмжүүр юм. (Хүмүүс энэхүү тоглоомонд анх удаа оролцож байгаа бол өөрөө жишээ болгон зогсож үзүүлэх хэрэгтэй).
- Оролцооны талаарх өгүүлбэрийг сонсмогцоо өөрийн оролцоонд тохирсон түвшинд очиж зогсоно. Тэрхүү зай нь үнэмлэхүй хоёр тэмдгийн хооронд байна. (жич: Хүүхдүүд анх энэ тоглоомонд оролцохоороо хажууд байгаа хүнээ дагах хандлагатай байдаг тул яг өөрийнхөө бодож байгаагаар зогсохыг маш сайн ойлгуулж өгөх хэрэгтэй.)
- Тоглоомд оролцогчид хэрхэн ялгаатай газар зогссон болохыг нь өөрсдөд нь анзааруулж байх нь чухал.
- Нэг юмуу хоёр хүнийг зогсож байгаа газраа яагаад зогсохоор шийдсэнийг нь тайлбарлуулна. (нэг нь өөрийгөө ердөө оролцдоггүй хэмээн тодорхойлсон, харин нөгөө нь өөрийгөө маш идэвхтэй оролцдогт тооцож байгаа хоёр хүнээр тайлбарлуулбал зүгээр). Хүмүүсийг бусдынхаа тайлбарыг хүлээцтэй сонсох, хүсвэл өөрөө яагаад тэр байрлалд зогсох болсноо тайлбарлах боломжийг олгоорой.
- Дараагийн картыг уншиж үйл явцаа үргэлжлүүлнэ. (жич: Өөрөө байнга уншиж танилцуулах биш, харин картыг танхимын голд байрлуулсан сандал дээр доош харуулж тавиад сайн дураараа гарч ирж, картыг бусаддаа уншиж өгөхийг урьж болно)
- Тоглуулагч та өөрөө маш түргэн шаламгай байж, цагт багтаан бүх картыг уншиж дуусгахыг хичээх хэрэгтэй.
- Тоглоомоо дуусгаад нийтийн хэлэлцүүлэг хийхээр тойрч сууцгаана. Хэлэлцүүлэг дээр дараах асуултуудыг тавьж болно:
  - Нийгэм дэх оролцооныхоо талаар юуг мэдэж авсан бэ?
  - Бид нийгмийн ямар нэг үйл ажиллагаанд бусад үйл ажиллагаанаас арай түлхүү оролцож байна уу? Яагаад?
  - Хөвгүүд ба охидын оролцооны хооронд ялгаа ажиглагдав уу?
  - “Оролцоо” –ны утга агуулгыг ойлгоход энэ тоглоом яаж туслав?

Жич : тодорхой нэг бүлгийн оролцооны талаарх анхан шатны мэдэгдэхүүн авах гэж байгаа тохиолдолд хоосон зайны диаграмыг цаасан дээр буулгах хэрэгтэй. Цаасан дээр хүмүүсээ цэгээр тэмдэглээд гарчгийг нь тодорхой өгөхөө мартаж болохгүй.

**“Би хэрхэн оролцдог вэ?” карттай тоглоом**

хувилж аваад хайчлаарай 

	<b>хот суурингийнхаа урлаг соёлын арга хэмжээнд;</b>
<b>эрүүл мэндийн үйлчилгээний талаарх шийдвэрт;</b>	<b>сүмийн болон шашны үйл ажиллагаанд;</b>
<b>сургууль, коллежийнхоо шийдвэр гаргах үйл явцад;</b>	<b>байгаль орчноо хамгаалах үйл ажиллагаанд;</b>
<b>насанд хүрэгчдээс бүрдсэн хороо, ажлын хэсгийн үйл ажиллагаанд;</b>	<b>улс төрийн намын үйл ажиллагаанд;</b>
<b>орон нутгийн зохион байгуулалтанд;</b>	<b>дүүрэг, тосгоны зөвлөлийн шийдвэр гаргалтанд;</b>
<b>гэр бүлийнхээ шийдвэр гаргалтанд;</b>	<b>хүүхэд удирдлагатай, эсвэл залуучуудын байгууллагад;</b>
<b>хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд;</b>	<b>ТББ-ын шийдвэр гаргалтанд;</b>
<b>орон нутгийн хүүхдийн зөвлөл, парламентад;</b>	<b>орон нутгийн болон үндэсний хэмжээний кампанит ажилд</b>

## 2 ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Энэхүү арга хэмжээ нь гурван хүснэгтийг бөглөхөд тань дэмжлэг болох юм. Оролцогч бүрт өөр өөр өнгийн наадаг зурагнуудыг хуваарилж, шалгуур үзүүлэлт бүр дээр гарч байгаа өөрчлөлт дэвшлийг үнэлэх зураглал гаргуулаарай. Хүүхэд, залуус, төрийн байгууллагын удирдлагууд, эцэг эхчүүд гэх мэт янз бүрийн оролцогчдыг хамруулж байгаа бол бүлэг тус бүрт өөр өөр өнгийн наадаг зураг, харин бүлэг нэг бүрээр тусгай уулзалт хийж байгаа бол тухайн бүлгээ дотор нь дахин бүлэгт хувааж болно. Жишээлбэл, зөвхөн хүүхдүүдийг оролцуулсан хэлэлцүүлэг хийх бол тэднийг охид, хөвгүүдээр, эсвэл насны бүлгээр ангилж болно. Хүүхдийн эрхийн мэргэжилтнүүдийг оролцуулж байгаа тохиолдолд багш нар, нийгмийн ажилтнууд, цагдаа гэх мэтээр бүлэглэх хэрэгтэй.

### Шаардагдах хугацаа

Дээр дурдсанчлан ямар үр дүн эрэлхийлж байгаагаас тань хамааран хэдэн өдрөөр ч үргэлжилж болох юм.

### Шаардагдах хэрэгсэл

- Гурван хүснэгтийг томоор хэвлэж хананд өлгөсөн байх (нэмэгдэх шалгуур үзүүлэлтүүд багтах зайтай).
- хэлэлцүүлэгт оролцогчдыг хэдэн бүлэгт хувааж байгаагаас хамаараад төдий чинээ олон өнгийн харандаа, наадаг цаас.
- Оролцогчид хүснэгтүүдийг чөлөөтэй харж болохоор зай талбай.










### Явц

- Хүүхдийн оролцоог хангах орчин бүрдсэн эсэхийг үнэлэхийн ач холбогдлыг тайлбарлаж өгнө. Энэхүү арга хэмжээ нь ямар нэг төсөл хөтөлбөрийн үр дүнг бус нийгэм дэх хүүхдийн оролцоо ямархуу түвшинд явааг судлах өргөн хүрээг хамарсан зорилготой болохыг ойлгуулаарай. Оролцогчдод асуулт асуух, өөрсдийнхөө бодол санааг цэгцлэх цаг өгөх
- Лекцийн тэмдэглэлэрхүү том дэвтрүүд дээр хүснэгтүүдийг хэвлэж, хана дагуу байрлуулсан байна. бүх оролцогчид хүснэгтийг харах боломжтой байх ёстой ба бүх өгүүлэмжид өөрийн үнэлэлт дүгнэлтийг өгнө. Хүүхдүүдийн бүлэгтэй ажиллаж байхдаа тэдэнд илүү ойлгомжтой байхаар өгүүлбэрүүдийг өөрчилж бичих хэрэгтэй.

Жишээ нь:

	Хангалтгүй	Хязгаарлагдмал	Боломжийн	Иж бүрэн
				
<b>7 Асран хамгаалал шаардлагатай хүүхдүүд өөрт хамааралтай тухайн асуудлыг шийдвэрлэхэд оролцож чаддаг эсэх</b>	Хүүхдээс хамааралгүйгээр томчууд энэ асуудлыг дангаараа шийддэг	Хүүхдийн санал бодлыг авч үзэхийг хуулиндаа заагаагүй	Хүүхэд өөрт хамааралтай асуудлаар шийдвэр гаргахад оролцох ёстойг хуульчилсан ба тэдний санал бодолд зохих ач холбогдол өгдөг. Гэвч хэрэгжилт маш сул.	
<b>8 Сургуулийн орчинд ардчиллын үйл ажиллагаанд хамрагдах эрх</b>	Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх индэр болсон ямар нэг зөвлөл, байгууллага байхгүй	Туршилт маягаар зарим сургуульд сурагчдын зөвлөлийг байгуулсан байдаг ба хамгийн сайн гэсэн сурагчлаа багш нар томилдог. Сурагчид янз бүрийн асуудлын талаар хэлэлцдэг ч шийдвэр гаргахад нөлөө үзүүлдэггүй.	Ихэнх сургууль сурагчдын зөвлөлтэй. сурагчид зөвлөлийн гишүүдээ өөрсдөө сонгодог. Харин шийдвэр гаргалтанд нөлөөлөх боломжоор хязгаарлагдмал байдаг.	Чухал шийдвэр гаргалтанд хяналт тавих оролцох эрх бүхий сурагчдийн зөвлөл, удирдах хороо сургууль бүрт байдаг ба тус зөвлөл нь сурагчдын ямар ч бүлгийг бүрэн төлөөлдөг.

- Дараа нь оролцогчид өрөөгөөр явж хүснэгтүүдийг ахин уншина. ойлгогдохгүй өгүүлэмж байвал асууж лавлах бололцоо олгоорой.
- Оролцогчид үзүүлэлтүүдийн тухай бие биенээсээ лавлавал тухайн өгүүлэмжийг аль аль нь зөв ойлгосон эсэхээ мэдэхэд илүү хялбар байх болно. Өөрийн орны нөхцөл байдалд илүү тохиромжтой болгохын тулд тухай шалгуур үзүүлэлтийн өгүүлэмжийг өөрчлөх, нэмэх боломжтой байх ёстой.
- Урвайснаас инээмсэглэсэн царай руу шилжих багануудын аль нэг дээр наадаг цаасаа наах, будахыг үүрэг болгоорой.

Оролцогч	Наадаг зурагны өнгө
Охид	
Хөвгүүд	
Ээжүүд	
Аавууд	
Нийгэмлэг болон шашны удирдагчид	
ТББ-ын ажилтнууд	
Орон нутгийн удирдлагууд	
Үндэсний удирдлагууд	
ОУ-ын ТББ/НҮБ-ын ажилтнууд	

Оролцогч бүрт, үзүүлэлт нэг бүрийг сайтар тунгаан бодохыг захиарай. Наадаг зургаа хаана байрлуулахаа шийдэхийнхээ өмнө бүлгээрээ богино хугацаанд зөвлөлдөж ч болно.

- 6 Сайтар бодолцсоны эцэст наадаг зургаа наах хэрэгтэй. эгнээ бүрт наах хангалттай хэмжээний наадаг зураг байх ёстой. Наадаг цаас өгч, сэтгэгдэл, нэмэлт тайлбарыг нь бас наалгаж болох юм. Энэ үед хүснэгт бүрийн хажууд хэлэлцүүлгийг удирдагчдаас (судлаачдаас) нэг хүн байлцаж, асуух лавлах зүйл гарвал хариулт өгч байх хэрэгтэй. Наадаг зургаа хаана байрлуулахаа шийдэх үеийн бүлгийн ярилцлагыг судлаач бичиж авч бас болно.
- 7 Бүлэг бүр наадаг зургаа нааж дууссаны дараа, цайны завсарлага авна.
- 8 Нийтийн хэлэлцүүлэг эхлэхэд бүлэг тус бүрийн өгсөн оноо үнэлгээний зүй тогтлыг ажиглахыг санал болгоно. Хоорондоо ялгаатай байр суурь нь өгсөн үнэлгээнээс нь ямар нэг байдлаар ажиглагдаж байгааг олж харах болно. Оролцогчдыг дараах асуултуудыг өөрөөсөө асуухыг зөвлөөрэй:
- Ерөнхий дүр зураг юуг харуулж байна вэ? Хүүхдийн оролцоог хангах орчин үндэсний болоод орон нутгийн хэмжээнд ямар байдалтай байна вэ?
  - Хамгийн доогуур үзүүлэлттэй нь юу байна? Хамгийн сайн үзүүлэлттэй нь аль вэ?
  - Орчин нөхцөл бүрдсэн байсан ч энэ нь хүүхэд бүрт хүртээмжтэй байж чадаж байна уу? Зөвхөн хэсэг бүлэг хүүхдүүдэд л хүртээмжтэй байгаа гэж бодож байвал ямар бүлгийн хүүхдүүд илүү ашиг тусыг нь хүртэж байна вэ?
  - Байр суурийн хооронд ихээхэн ялгаа байна уу? Тийм бол ямар үзүүлэлтүүд дээр ажиглагдаж байна? Шалтгааныг олж мэдээрэй.
  - Хүүхэд болон томчуудын хамгийн их ялгаатай үнэлж байгаа хэсэг нь аль вэ? Яагаад ийм байна? Өөр бүлгүүдийн хооронд мэдэгдэхүйц ялгаа байгаа эсэх?

Энэ хэлэлцүүлэг нь бүтэн өдөр ч үргэлжилж магадгүй тул дундуур цайны завсарлага авах цагаа тооцоолох хэрэгтэй. Зарим үзүүлэлтүүдийг оролцогчид үнэлж чадахгүйтэй таарч болох юм. Жишээ нь хүүхдийн байгууллагуудын яг хүүхдээр удирдуулж байна уу, эсвэл хууль журам, бодлого боловсруулахад янз бүрийн насны хүүхдүүд оролцож байгаа эсэх талаар мэдээлэл тэдэнд байхгүй байж болно. Мэдээлэл хугас байгаа үзүүлэлт дээр тэмдэглэгээ хийх хэрэгтэй. Дараа нь энэ тухай мэдээллийг олж, тус үзүүлэлтийг өөрөө бөглөж болно. Бүр ямар ч мэдээлэл олдохгүй байвал хүснэгтэн дээрээ тэмдэглэл хийгээрэй.

“Зөгийн бүлгэм” байгуулж, хэт удаашрах асуудлаас зайлхийж болно. “зөгийн бүлгэм” нь хоёр юмуу гурван хүний бүрэлдэхүүнтэй байна. Бүлэг бүрээс нэг нэг ийм бүлгэм сонгогдож, яригдаж байгаа асуудлаарх бүлгийн байр суурийг төлөөлнө. Эсвэл, хүүхдийн ээлжит уулзалтуудаар долоо хоногт нэг удаа нэг хүснэгт бөглүүлэх замаар мэдээ цуглуулж болно. Гэхдээ, ямар ч байсан төрөл бүрийн оролцогчдыг нэг дор цуглуулах нь сонирхолтой мэдээ цуглуулах хамгийн сайн арга мөн. Хамгийн гадурхагдсан болон эмзэг бүлгийн хүүхдүүдийн ч оролцооны байдлыг дүгнэхийн тулд зарим үзүүлэлтүүдийн үнэлгээг нас, хүйс, гарал угсаа, нийгмийн давхрага, хот хөдөөгийн харьяалал, мөн бусад хүчин зүйлсээр ялгах хэрэгтэй.



Никарагуагийн Ла Далиа дахь судалгаанд оролцогч хүүхдийн баг ажлаа эхлэхийн өмнө бие халаах тоглоом тоглож байна.

### ҮЗҮҮЛЭЛТ БҮРИЙН ЭЦСИЙН ОНООГ ГАРГАХ НЬ

Хүснэгтүүдэд байгаа үзүүлэлт бүрийн өгүүлэмжийн тухай ойлголт нь оролцогч бүрийн хувьд ялгаатай байдаг. Үзүүлэлт бүр дээр нэгдсэн зөвшилцөлд хүрч бүлэг нэгдмэл дүгнэлт гаргахад дараах зөвлөмжүүд тус болно.

### “ҮНЭЛЭМЖИЙН ШУГАМ” ЯРИЛЦЛАГА

Санал бодлын зөрүүтэй байдлын үед энэхүү аргыг хэрэглэвэл тохиромжтой. Энэ аргыг хэрэгжүүлэхдээ оролцогчид нэг шугаманд зогсож бие биенийхээ санал бодлыг сонсох юм. оролцогчдын харилцан яриаг судлаачид дэмжиж, үргэлжлүүлж өгөх хэрэгтэй. Харилцан ярилцсаны үр дүнд оролцогчид тохиромжтой нэг үнэлгээн дээр санал нэгдэх магадлал өндөр байдаг юм.

### Шаардагдах хугацаа

Нэг өдрөөс хэтрэхгүй (асуудлын хамрах чиглэл, салбарын хүрээнээс хамааран өөрчлөгдөнө).





### Шаардагдах хэрэгсэл

- Оролцогчдыг нэг шугаманд жагсаах зай талбай
- Шугамыг тэмдэглэх өнгийн скоч, эсвэл том цааснууд photo:



**Явц**

- 1 Нэг бүлгийн оролцогчид хоорондоо ялгаатай үзэл бодолтой байсан учраас, ялгаатай үнэлгээг өгсөн тул энэ ялгаагаа олж мэдэх зорилгоор харилцан ярилцахын ач холбогдлыг тайлбарлаж өгнө. Харилцан яриагаа эхлэхээсээ өмнө оролцогчид бие биенийхээ байр суурийг хүндэтгэх талаар тодорхой дүрмүүдийг дагаж мөрдөх ёстой. Бусдын санаа бодлыг сонсох эрмэлзэлтэй бөгөөд маш нээлттэй илэн далангүй байх нь чухал. Ингэснээрээ тодорхой нэг үзүүлэлт дээр өгсөн дүгнэлтээ өөрчлөх, шинэчлэх улмаар тус өгүүлэмж дээр нэгдмэл ойлголцолд хүрэх боломжтой гэдгийг тайлбарлаж өгөөрэй.
- 2 Хүмүүсээс авсан үнэлгээнийхээ хувьд аль шалгуур үзүүлэлт дээр хамгийн олон янзын байр суурь илэрхийлэгдэж байгааг олж хараарай. “Үнэлэмжийн шугам” харилцан яриагаар хэлэлцэгдэж болох 10 хүртэлх тооны үзүүлэлтийг сонгож авч болно.
- 3 Танхимын дотор нэг том эгнээ үүсгэ. Эгнээний нэг зах нь хүснэгт 1-ийн “хангалтгүй”, хүснэгт 2-ын “ойлголт хангалтгүй”, хүснэгт 4-ийн “оролцоо байхгүй” гэх мэт хамгийн муу үнэлэмжүүд, харин нөгөө тал нь “иж бүрэн хангалттай” буюу хамгийн сайн үнэлэмжүүдийг төлөөлнө. Үүнийг “үнэлэмжийн шугам” гэнэ.

Хууль эрхзүйн орчин	Хангалтгүй	Хязгаарлагдмал	Боломжийн	Иж бүрэн
				

- 4 Оролцогчид шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт хэр байгаа талаар өөрийн байр суурьт хамгийн ойр санагдсан хэсэгтээ очиж зогсоно.
- 5 Хүмүүс байрлалаа эзэлж дууссаны дараа яагаад тухайн байрлалд очихоор шийдсэнийг асууж тайлбарлуулна. Ялгаатай бүлгийн оролцогчдын үзэл бодлыг бие биенд нь сонгоно. Энэ үед зарим хүмүүс нь бусдын байр сууриа баталгаажуулж буй үндэслэлтэй санал нийлж байгаагаа илэрхийлэн байрлалаа сольж болно.
- 6 Одоо нийтийн хэлэлцүүлэгт шилжинэ. үзэл бодлын ялгаатай байдлын тал дээр хамгийн чухал сэдвүүдийг олж хөндөөрэй. Жишээлбэл, зарим нэг үзүүлэлт дээр томчууд хүүхдүүдийн байр суурийн хооронд ихээхэн ялгаа байсан уу? мөн бусад бүлэг оролцогчдын дунд? үзэл бодлын ийм илт ялгаа гарахад юу нөлөөлөв?
- 7 харилцан ярилцсаны дүнд бүлэг дундаа нэг ойлголцолд хүрч чадаж байгаа эсэхийг үзнэ.
- 8 бүлэг хоорондын үзэл бодлын ялгааг хамгийн их илэрхийлсэн үзүүлэлт бүр дээр дээрх дарааллыг баримтлан хэлэлцүүлгээ үргэлжлүүлнэ.
- 9 Мэдээ цуглуулах судалгаанаас өргөн хүрээний нэгдмэл ойлголтыг олж авч чадсан бол улс орныхоо хэмжээнд хүүхдийн оролцох эрхийн хэрэгжилт ямар түвшинд байгаа тухай нарийвчилсан төсөөлөлтэй боллоо гэсэн үг. Харин үүнийхээ дараа олж авсан мэдээллээ хэрхэн, юунд ашиглах гэж байгаагаа оролцогчдод тайлбарлаж өгөх хэрэгтэй. Хүүхэд, залуустай ярилцаж, тэдний юу хийх хүсэлтэй байгааг харгалзан үзэж болно. Жишээ нь, хүүхэд залуус цугларсан мэдээллийг ашиглан төр засаг болон Хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтийг хангах хороонд тайлан гаргаж өгөх сонирхолтой байж болох юм. Мөн хүүхдийн эрхий асуудлаар зөвлөмж боловсруулах, аян зохион байгуулахдаа баримтлах гол чиглэлээ тодорхойлоход нь судалгаанаас цугларсан мэдээлэл хэрэг болж ч мэднэ. Мэдээ цуглуулах судалгааны хамгийн чухал үр дүн юу байв? Ямар өөрчлөлтийг хийж болох юм шиг санагдав? Энэ өөрчлөлтийг хийхэд ямар хүмүүс түнш болон ажиллах сонирхолтой байна вэ?

# ДҮГНЭЛТ

Хүүхдийн эрхийн хэрэгжилтэнд оролцдог гол этгээдүүдийг цуглуулан, дээрх хүснэгтүүд дээр үнэлгээ авч, үзэл бодлыг нь мэдэх нь өөрөө нэлээд ач холбогдолтой. Юуны өмнө, энэхүү үйл ажиллагааг явуулснаар НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн нийгэм дэх хүүхдийн гүйцэтгэх үүрэг, тэдгээрийн эзлэх байр суурийн талаарх учир холбогдлыг судалгаанд хамрагдсан бүх хүмүүст таниулж байгаа юм. Хоёрдугаарт, хүүхдийн үзэл бодол, хүсэл эрмэлзлийг нийтэд сонсох нэг индэр болж өгнө. Насанд хүрсэн оролцогч талуудын, хүүхэд залуусын туршлага мэдлэг, үзэл бодлын талаарх болон тэдгээр хүүхэд залуус шийдвэр гаргах үйл явцад хэр хэмжээнд оролцож байгаа, хэр хэмжээнд оролцохыг хүсдэг талаарх ойлголтыг илүү сайжруулна. Нийгэмд ямар өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай байгааг олж мэдэх, сурвалжлах орон зайг мөн бий болгож байна. Гуравдугаарт, хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг үнэхээр хүндэтгэдэг эсэх талаарх томчууд хүүхдүүдийг ялгаатай байр суурийг илтгэх хүчин зүйл болно. Тухайлбал, бүх сургуулиудад хүний эрхийн хөтөлбөр баталж хэрэгжүүлэхийг даалгаснаараа төрийн байгууллагын удирдлагууд хүүхдийн эрхийг хангах тал дээр нэлээд ахиц гаргасан гэж боддог байхад сургуулийн сурагчид бодит байдал дээр өөрийн оролцох эрхээ эдэлж чаддаггүй, эрхийнхээ талаар ч, багш нар тийм сургалтын хөтөлбөрийн дагуу ажиллах ёстой талаар ч мэдлэггүй байж байх нь олонтаа. Ийм учраас энэхүү судалгаа нь төр засаг бодлогынхоо үр нөлөө, хэрэгжилтийн бодит байдлыг мэдрэхэд тусалдаг байна.

Ерөнхийдөө, энэхүү хүснэгтүүдийг бөглөснөөр та ажиллаж байгаа улсынхаа нийгэмд хүүхдийн оролцоо хэрхэн хэрэгжиж, хүндэтгэгдэж байгаа тухай маш тодорхой ойлголттой болж байгаа юм. Тодорхой цаг хугацаанд гарсан өөрчлөлтийг хэмжих шалгуур, сургалт ба мэдрэмжийн судалгааны хэрэгсэл, эсвэл зөвлөмж боловсруулахад аргачлал болон хэрэглэгдэх мэдээллийг та цуглуулж чадна.



Үерийн дараа хүүхдүүдэд барьж өгсөн аюулгүй тоглоомын талбай, Пакистан

# АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

<sup>1</sup> CRC General Comment No.12, The Right of the Child to be Heard, CRC/C/GC/12, July 2009

<sup>2</sup> General Comments are documents produced by the Committee to help governments understand a particular article in the Convention, or a particular issue. For example, in addition to Article 12, there are several General Comments including one on Article 19, the right to protection from all forms of violence, one on children with disabilities, and one on adolescent health. You can see all the General Comments at: <http://www2.ohchr.org/english/bodies/crc/comments.htm>

<sup>3</sup> See, for example, Take Us Seriously, UNICEF, [https://www.dropbox.com/s/sov6fxomlxwp9lk/Guidelines\\_Brochure\\_for\\_formatting\\_rev.pdf](https://www.dropbox.com/s/sov6fxomlxwp9lk/Guidelines_Brochure_for_formatting_rev.pdf)

<sup>4</sup> This tool was developed and shared by Harry Shier, from CESESMA, a Nicaraguan NGO

# ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ДҮГНЭХ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ХЭРЭГСЛҮҮД

ТОВХИМОЛ

2

ХҮҮХДЭД ХҮНДЭТГЭЛТЭЙ, ОРОЛЦООГ  
ХАНГАСАН ОРЧИН БҮРДҮҮЛСНИЙГ ҮНЭЛЖ  
ХЭМЖИХ ТУХАЙ ГАРЫН АВЛАГА

Арга хэрэгслийн багц нь хүүхдийн оролцоог хэмжих үзэл баримтлалын үндэслэл, ХШҮ хийх удирдамж, шаардлагатай мэдээллээ авахад хэрэглэх арга хэрэгслүүдийг багтаасан. Шууд хүүхэдтэй ажилладаг байгууллагууд, хүүхдийн удирдлагатай, залуучуудын удирдлагатай байгууллагууд, хүүхдийн оролцох эрхийг хангах үүргээ хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа төрийн байгууллагууд энэхүү арга хэрэгслийн багцыг хэрэглэж болно.

Арга хэрэгслийн багц зургаан товхимлоос бүрдэнэ. Үүнд:

**Товхимол 1–д** арга хэрэгслийн багцын тухай үндсэн мэдээлэл, хүүхдийн оролцооны тойм мэдээлэл багтсан. Мөн ХШҮ–ний товч удирдамж, гол нэр томъёолол, холбогдох эх сурвалжуудын мэдээллийг агуулсан.

**Товхимол 2–г** тухайн улс орон, нөхцөл байдалд хүүхдийг хүндэтгэх, хүүхдийн оролцоог хангах орчин бүрдсэн байдлыг хэмжих суурь, хэрэгжүүлэх арга замыг заасан. Үүнд:

а) оролцох эрхийг хамгаалах; б) оролцох эрхийг сурталчлан таниулах; в) оролцох орон зай бий болгох.

**Товхимол 3–г** аливаа орчинд хүүхдийн оролцооны цар хүрээ, чанар, үр дүнг хэмжих үзэл баримтлалын суурийг танилцуулна. Түүнчлэн хүүхдийн оролцоонд ХШҮ хийх ажлын үр дүнг дээшлүүлэх зорилготой жишиг хэмжүүрүүд болон матрицуудыг үзүүлнэ.

**Товхимол 4–г** оролцоот ХШҮ–ний үйл ажиллагааг хүүхдүүд болон бусад оролцогч талуудтай хэрэгжүүлэх 10 алхамт удирдамж багтсан. Түүнчлэн зорилго, зорилтуудаа хэрхэн томъёолох, явц ахицыг хэмжих үзүүлэлтүүдийг хэрхэн тодорхойлох, цэгцтэй өгөгдөл цуглуулах, баримтжуулах, ХШҮ–ний мэдээлэлд дүн шинжилгээ хийх удирдамжийг оруулсан.

**Товхимол 5–д** хүүхдийн оролцооны чанар, цар хүрээ, үр дүнд ХШҮ хийх зорилгоор хүүхэд, залуучуудтай болон бусад оролцогч талуудтай ажиллахад тохиромжтой арга хэрэгслүүдийг оруулсан. Зарим арга хэрэгслийг Товхимол 3 дахь матрицтай холбоотой мэдээлэл цуглуулахад зориуд тохируулсан байгаа.

**Товхимол 6** нь арга хэрэгслийн багцыг туршин хэрэгжүүлэхэд оролцсон хүүхэд, залуучуудын бүтээл юм. Үүнд хүүхдийн оролцооны ХШҮ–ний ажил хийхдээ санах зүйлсийн талаар насанд хүрэгсэд, хүүхэд, залуучуудад зориулсан удирдамж орсон билээ.

[savethechildren.org.uk](http://savethechildren.org.uk)



Save the Children